




ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүн”-д
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



**Өрийн удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрэн
бүрдээгүйгээс бодлого, зохицуулалтын үр дүн
хангалтгүй байна**

Улаанбаатар хот
2017 он

Тайланг бэлтгэсэн:

 Үндэсний аудитын газрын
 Гүйцэтгэлийн аудитын газар

 Газрын захирал бөгөөд
 тэргүүлэх аудитор

М.Давааням

Аудитын менежер

З.Ариунзаяа

Ахлах аудитор

Д.Гандолгор

Б.Болормаа

Аудитор

Ц.Цолмон

Э.Уянга

М.Гүнжмаа

Б.Ариунжаргал

Х.Энх-Амгалан

Н.Эрдэнэбаяр

С.Одонцэцэг

2017 оны 6 дугаар сар

 Уг тайланг YAG-ын
 цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.mn

 Аудитын тайлантай холбоотой
 асуудлаар нэмж тодруулах,
 асууж лавлах зүйл байвал 263755
 дугаарын утас, 323266 дугаарын
 факсаар харилцана уу.

ХАЯГ:

 Үндэсний аудитын газар
 Засгийн газрын 4 дүгээр байр,
 Бага тойруу-6, Улаанбаатар-
 15160, Монгол Улс

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, графикийн тайлбар	4
Аудит хийсэн үндэслэл	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ	5
Аудитын арга зүй.....	5
Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа	5
Ерөнхий мэдээлэл	7
Засгийн газрын гадаад өрийн талаар	7
Засгийн газрын дотоод өрийн талаар	8
БҮЛЭГ 1. Өрийн удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрэн бүрдээгүй нь өрийн бодлого, зохицуулалтын үр дүн хангалтгүй байх шалтгаан болжээ.....	9
Өрийн удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.....	9
Өр үүсгэх хэрэгцээ шаардлагыг оновчтой төлөвлөөгүйгээс зарим төсөл үр дүнд хүрээгүй байна	10
Өрийн удирдлагын дунд хугацааны зорилт бүрэн биелээгүй байна	10
Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг шинэчлэх шаардлага үүссэн байна.....	11
Өрийн мэдээллийг ялгаатай аргачлалуудаар боловсруулж байна.....	12
БҮЛЭГ 2. Өрийн зохистой түвшин алдагдаж, өрийн хэмжээ сэрэмжлэх түвшинд хүрсэн байна.....	13
Өрийн тусгай шаардлагын түвшинг тогтвортой баримтлахгүй байна	13
Өрийн тогтворгүй байдал үүсч сэрэмжлэх түвшинд хүрсэн байна.....	13
Гадаад валютын албан нөөцийн хэмжээ богино хугацаат гадаад өр төлбөрийг барагдуулахад хүрэлцэхээргүй хэмжээнд байна	14
Төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөхгүй байгаа нь дотоод өр нэмэгдэх, хүүгийн зардалд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үндсэн шалтгаан болж байна.....	15
Засгийн газрын өрийн хүлээгдэж буй төлбөрийн хуваарь нь төсөвт их хэмжээний ачаалал үзүүлэхээр байна.....	16
Нэгдсэн төсвийн зарлагын дүнд эзлэх өрийн үйлчилгээний хүүгийн зардлын эзлэх хувь хэмжээ нэмэгдсээр байна	17
БҮЛЭГ 3. Өр үүсгэж бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй, валютын ханшийн эрсдэлийг удирдаагүйгээс үр ашиггүй нэмэлт зардал гарсаар байна	18
Өр үүсгэж бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна	18
Дамжуулан зээлдүүлсэн зээлийн 45 хувь нь төлөгдөх боломжгүй байна	18
Гадаадын валютын ханшийн эрсдэлийг зохистой удирдаагүйгээс төсвийн үр ашиггүй зардал нэмэгдсээр байна	19
Векселийн төлбөр, концессын гэрээнүүдэд өрийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс ханшийн зөрүү болон хүүгийн нэмэлт төлбөрийн үр ашиггүй зардал гарч байна	20
Төсвийн орлогыг зохистой төлөвлөөгүйгээс векселийн төлбөрийн хүүгийн нэмэлт зардалд төсвийн ихээхэн хэмжээний хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж иржээ	21

БҮЛЭГ 4. Өрийн мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаж чадахгүй байна.....	22
Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажил хангалтгүй хийгдэж байна.....	22
Концессын талаарх мэдээллийн санг бүрдүүлээгүй байна.....	22
Олон нийтэд мэдээлэх чиг үүргээ биелүүлээгүй байна.....	22
БҮЛЭГ 5. Өрийн удирдлагын хариуцлагатай байх зарчим бүрэн хэрэгжихгүй байна	24
Холбогдох шийдвэргүйгээр дотоод зээл авсан, хуульд нийцээгүй баталгаа гаргасан зөрчил гаргажээ	24
Төслийн хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна	24
Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.....	25
Концессын гэрээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна	26
Дүгнэлт.....	27
Зөвлөмж.....	28
Хавсралт.....	29
Холбогдох байгууллагын санал.....	32
Үндэсний аудитын газрын тайлбар	35

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АҮЯ	Аж үйлдвэрийн яам
АХБ	Азийн хөгжлийн банк
БНАУ	Бүгд Найрамдах Австри Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕХСБХБ	Европын холбооны сэргээн босголт, хөгжлийн банк
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗТЯ	Зам тээврийн яам
ЗТХЯ	Зам тээвэр хөгжлийн яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТБХБЯ	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
ЗТЭ	Зээлжих тусгай эрх
МИАТ	Монголын Иргэний Агаарын Тээвэр
НААҮБ	Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллага
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨ	Орон нутгийн өмч
ОСНААҮ	Орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээ
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОУХА	Олон Улсын хамтын ажиллагаа
ӨБЦТС	Өмнөд бүсийн цахилгаан түгээх станц
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
тбм.төг	Тэрбум төгрөг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТБТХ	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХААЯ	Үйлдвэр хөдөө аж ахуйн яам
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХХС	Хүний хөгжил сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЦШСГ	Цахилгаан шуудан сүлжээний газар
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ЭБЭХС	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
ЭМСЯ	Эрүүл мэнд, спортын яам
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭХС	Эрчим хүчний станц
ЭХЯ	Эрчим хүчний яам
DMFAS	The Debt management and Financial analysis system
DSA-MAC	Debt Sustainability Analysis for Market-Access Countries /зах зээлд нэвтрэх боломжтой улс орнуудад зориулсан өрийн тогтвортой байдлын шинжилгээ/
DSA-LIC	The Debt Sustainability Analysis for Low-Income Countries /бага орлоготой улс орнуудад зориулсан өрийн тогтвортой байдлын шинжилгээ/
ODAMIS	Official development assistance management information system

Хүснэгт, графикийн тайлбар

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл	7
Хүснэгт №2	Засгийн газрын өрийн үлдэгдэл /нэр төрлөөр/	7
Хүснэгт №3	Дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын зорилт	10
Хүснэгт №4	Олон улсад зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудаас тогтоосон Монгол Улсын зээлжих зэрэглэл	10
Хүснэгт №5	Өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн дунд хугацааны бодлогын хүрээний хүрэх үр дүн, гүйцэтгэл	11
Хүснэгт №6	Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэлд нөлөөлсөн ханшийн өөрчлөлт	11
Хүснэгт №7	Засгийн газрын гадаад өр	12
Хүснэгт №8	Монголбанк, Сангийн яамны өрийн мэдээллийг боловсруулах аргачлал	12
Хүснэгт №9	Засгийн газрын гадаад үнэт цаасны бүртгэлийн ялгаа	12
Хүснэгт №10	Засгийн газрын өрийн тусгай шаардлагын хүрэх түвшингийн гүйцэтгэл	13
Хүснэгт №11	Өрийн тогтвортой байдлын индикатор үзүүлэлт	13
Хүснэгт №12	Засгийн газрын дотоод үнэт цаас гаргалт	15
Хүснэгт №13	Концессын улс, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх хуваарь	16
График №1	Улсын өрийн удирдлага /чиг үүргийн хуваарилалт/	9
График №2	Гадаадын хөрөнгө оруулалт, экспортын орлого, гадаад валютын албан нөөц	14
График №3	Богино хугацаат өр төлбөрийг төлөхөд хүрэлцээтэй байдал	14
График №4	Гадаад валютын албан нөөц импортын 3 сарын хэрэгцээг санхүүжүүлж байгаа байдал	14
График №5	Эдийн засагт байгаа нийт мөнгөний 20 хувьтай тэнцэх байдал	14
График №6	Гадаад валютын цэвэр нөөц	14
График №7	Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /2016 оны байдлаар/	15
График №8	Жигнэсэн дундаж хүүгийн харьцуулалт	16
График №9	Засгийн газрын гадаад өр болон баталгаатай зээллэгийн эргэн төлөлтийн хуваарь	16
График №10	Засгийн газраас дотоодод гаргасан үнэт цаасны эргэн төлөлтийн хуваарь	16
График №11	Нэгдсэн төсвийн зарлага болон хүүгийн зардал	17
График №12	Дамжуулан зээлийн үлдэгдэл /салбараар/	18
График №13	Дамжуулан зээлийн үлдэгдэл /валютаар/	19
График №14	2015-2016 оны төсвийн орлогын биелэлт, бичсэн векселийн үндсэн болон хүүгийн төлбөр	21

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 2 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын аудитын ажлын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын өрийн удирдлагын үр нөлөө, өрийн хэрэгслээр дамжуулан бий болсон хөрөнгийн зарцуулалт үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтан болон УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ.

- Өрийн удирдлагын нэгдсэн тогтолцоотой эсэх;
- Өрийн зохистой түвшинг хангаж байгаа эсэх;
- Өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж байгаа эсэх;
- Өрийн мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа эсэх;
- Өрийн удирдлагын хариуцлагатай байх зарчим хэрэгжиж байгаа эсэх;

Аудитад Монгол Улсын нийт гадаад өр болон Засгийн газрын 2013-2016 оны байдлаарх нийт өрийн хэмжээ, түүний бүртгэл тайлагнал, Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, тусламж, түүгээр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, өрийн баталгаа, өрийн бусад хэрэгслээр үүссэн Засгийн газрын өрийг Монголбанк, Сангийн яам бусад ТЭЗ, холбогдох байгууллагуудыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам, АДБОУС 3000-3100, 5400-5499, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, Засгийн газрын өрийн удирдлагын талаарх аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ингэхдээ Засгийн газрын өрийн удирдлагатай холбоотой хууль, эрхийн актыг судлах, Улсын нийт гадаад өр болон Засгийн газрын өртэй холбоотой мэдээ, судалгаа, тооцоололд дүн шинжилгээ хийх, түүвэрчлэх, холбогдох байгууллагын мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж, тодруулга авах зэрэг аудитын арга зүйг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2013-2016 оны төсвийн тухай хуулиуд болон тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль (2015 оны 2 дугаар сарын 18-нд хүчингүй болсон);
- Өрийн удирдлагын тухай хууль 2015 он;
- Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг (УИХ-ын 2015 оны 51 дүгээр тогтоол);
- Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл (2013-2016);
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль;

- Төв банк (Монголбанк)-ны тухай хууль;
- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль;
- Векселийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Концессын тухай хууль;
- Үнэт цаасны тухай хууль;
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад хууль эрхийн актууд;
- УИХ-ын 2016 оны 81 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Улсын өрийн аудитын удирдамж АДБОУС 5400-5499;
- Сангийн сайдын 2015 оны 300 дугаар тушаалаар батлагдсан “Өрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах, төвлөрүүлэх, өр төлбөрийг бүртгэх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Бусад холбогдох хууль, эрхийн акт

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням хянан удирдаж, аудитын менежер З.Ариунзаяа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, тус газрын ахлах аудитор Д.Гандолгор, Б.Болормаа, аудитор Ц.Цолмон, Э.Уянга, Х.Энх-Амгалан, Б.Ариунжаргал, М.Гүнжмаа, Н.Эрдэнэбаяр, С.Одонцэцэг нар 2017 оны 2 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 9-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын нийт гадаад өр¹ 2013 онд 19.0 тэрбум, 2014 онд 20.9 тэрбум, 2015 онд 21.8 тэрбум, 2016 онд 24.3 тэрбум ам.долларт /өссөн дүнгээр/ хүрсэн байна.

Хүснэгт №1	Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл	/сая ам.доллар/			
	Үзүүлэлт	12/31/2013	12/31/2014	12/31/2015	12/31/2016
Засгийн газрын өр Үүнээс:		3,684.3	3,610.0	3,647.9	4,894.5
Гадаад үнэт цаас		1,500.0	1,500.0	1,417.8	2,047.0
Гадаад зээл		2,184.3	2,110.3	2,230.1	2,805.1
Вексель ²		-	-	-	42.4
Төв банкны өр		1,065.3	1,568.0	1,959.6	1,790.7
Хадгаламжийн байгууллага ³ -ын өр /Төв банкаас бусад/		1,298.1	1,629.0	2,045.0	2,438.1
Бусад салбарууд ⁴ -ын өр		2,633.4	3,522.0	3,501.3	8,084.4
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын өр		10,341.0	10,615.0	10,675.5	7,056.4
Нийт гадаад өр		19,022.1	20,942.3	21,829.4	24,264.1

Эх сурвалж: Монголбанк

2016 оны эцэст нэрлэсэн үнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр 22.3 их наяд төгрөгт хүрч, 56 хувийг гадаад өр, 29 хувийг дотоод өр, 15 хувийг Засгийн газрын баталгаатай зээллэг эзэлж байна.

Хүснэгт №2	Засгийн газрын өрийн үлдэгдэл /нэр төрлөөр/	/тэрбум төгрөг/			
	Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он	2016 он
		Улсын нийт өр		Засгийн газрын нийт өр ⁵	
Гадаад зээлийн үлдэгдэл		3,613.2	3,979.1	4,565.4 ⁶	6,983.3
Гадаад үнэт цаасны үлдэгдэл		2,481.2	2,828.4	3,315.8	5,380.5
I Засгийн газрын гадаад өр		6,094.4	6,807.5	7,881.2	12,363.8
Өрийн баталгааны үлдэгдэл		1,160.2	2,544.4	2,743.5	3,451.5
II Засгийн газрын баталгаатай зээллэг		1,160.2	2,544.4	2,743.5	3,451.5
Дотоод үнэт цаасны үлдэгдэл		1,849.6	2,964.1	3,333.2	5,488.8
Төрийн өмч ба Төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өр		1,629.3	1,438.3	-	-
ОНӨ ба ОНӨ давамгайлсан хуулийн этгээдийн өр		174.9	174.9	-	-
Татварын урьдчилгаа төлбөр /Оюутолгой/		372.5	138.7	41.4	-
Төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл		-	-	261.0	668.9
Векселийн өр		-	-	164.3	307.2
III Дотоод өр		4,026.3	4,716.0	3,799.9	6,464.9
Засгийн газрын нийт өрийн дүн (I+II+III)		11,280.9	14,067.9	14,316.0	22,280.2
Засгийн газрын ӨҮЦ-ээр тооцсон өрийн дүн		8,757.5	11,871.6	12,124.2	18,861.0

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын гадаад өрийн талаар

Гадаад зээл: Монгол Улсын Засгийн газар хөрөнгө оруулалтыг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, улс орны эдийн засгийн хөгжилд түлхэц болохуйц төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор 20 гаруй гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн үлдэгдэл 2012 оны эцэст 2,954.1 тэрбум төгрөг байсан бол 2013-2016 онд нийт 1,304.0 сая ам.доллар буюу 2,545.3 тэрбум төгрөгийн гадаад зээлийг авч 2016 оны эцэст 2,805.1 сая ам.доллар буюу 6,983.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. /хавсралт №1-ээр харуулав/

Гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт тайлант онуудад 773.6 тэрбум, үүнээс үндсэн төлбөрт 582.7 тэрбум, хүүгийн төлбөрт 190.9 тэрбум төгрөгийг төлжээ.

Гадаад үнэт цаас: 2013-2016 онд олон улсын зах зээлд нийт 661.2 сая ам.доллар буюу 1,336.3 тэрбум төгрөгийн гадаад үнэт цаас гаргаж, хүүгийн төлбөрт 718.5 тэрбум төгрөгийг төлж, 2016 оны эцэст Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2,161.2 сая ам.доллар буюу 5,380.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. /хавсралт №2-оор харуулав/

Засгийн газрын баталгаа: Монгол Улсын Засгийн газраас аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тэдгээрийн гадаад эх үүсвэрээс авсан өрийн хэрэгсэлд холбогдох хууль, эрхзүйн хүрээнд Засгийн газрын баталгааг гаргаж,

¹ Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.4 дэх хэсэгт “улсын нийт гадаад өр”-ийг Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээс Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн үүрэг”

² Ухаа худга-Гашуун сухайт чиглэлд төмөр замын суурь бүтэц барих төслийн Монгол Улсад бүртгэлгүй хөрөнгө оруулагчийн эзэмшиж байгаа Засгийн газрын вексель

³ Хадгаламж татан төвлөрүүлдэг байгууллагууд буюу Монгол улсын нийт арилжааны банкуудын эдийн засгийн харьяат бусаас авсан зээл, өрийн хэрэгслүүд

⁴ Төрийн банк, Хөгжлийн банк болон бусад Монгол Улсын харьяат аж ахуй нэгжүүдийн эдийн засгийн харьяат бусаас авсан зээл, өрийн хэрэгслүүд

⁵ Өрийн удирдлагын тухай хуулиар “Улсын өр”-ийн тодорхойлолтыг “Засгийн газрын өр” гэж өөрчилсөн ба Засгийн газрын өрд орон нутгийн өмчит болон орон нутгийн өмч давамгайлсан, төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжүүдийн өрийг оруулахгүй болсон

⁶ Засгийн газрын гадаад зээлийн 2015 оны жилийн эцсийн үлдэгдэл Засгийн газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 4,456.8 тэрбум төгрөг байсан бөгөөд Сангийн сайдын 2016 оны 442 дугаар тушаалаар 2015 оны төсвийн жилд гарсан ашиглалтыг зээлдүүлэгч талаас ирүүлсэн баримт, зээлийн үлдэгдлийг зээлдүүлэгч талтай тооцоо нийлж, тулган баталгаажуулсаны дагуу нөхөн бүртгэж, гадаад зээлийн үлдэгдлийг 4,565.4 тэрбум төгрөг болгон залруулан бүртгэсэн.

2016 оны эцэст баталгаат зээллэгийн үлдэгдэл 1,386.1 сая ам.доллар буюу 3,451.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. /хавсралт №3-аар харуулав/

Засгийн газрын дотоод өрийн талаар

Засгийн газрын дотоод өрийн 84.9 хувийг дотоод үнэт цаас, 10.3 хувийг улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын гэрээний дагуу үүссэн төлбөрийн үүрэг, 4.8 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын төлбөрийг баталгаажуулж бичсэн вексель тус тус эзэлж байна.

Дотоод үнэт цаас: 2013-2016 онд нийтдээ 11.7 их наяд төгрөгийн үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргаж, үндсэн төлбөрт 7.0 их наяд, хүүгийн төлбөрт 1.1 их наяд төгрөгийг төлсөн ба 2016 оны эцэст Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 5,488.8 тэрбум төгрөг байна. /хавсралт №4-өөр харуулав/

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 62.4 хувийг улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, 11.1 хувийг ХХС-гийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, 26.5 хувийг тусгай зориулалтаар гаргасан үнэт цаас тус тус эзэлж байна.

Дотоод зээл: Төв банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1⁷, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7⁸-д заасны дагуу Засгийн газар 2013-2016 онд төсвийн улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор ондоо эргэн төлөгдөх нөхцөлтэй нийт 300.0 тэрбум төгрөгийн дотоод зээлийг Монголбанкнаас авч тухайн ондоо үндсэн төлбөрийн хамт хүүнд 4.5 тэрбум төгрөгийг төлсөн ба 2016 оны жилийн эцсийн байдлаар дотоод зээлийн үлдэгдэлгүй байна.

Вексель: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний төлбөрийг баталгаажуулах, төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажилд зориулан 2015-2016 онд бичсэн нийт 697.2 тэрбум төгрөгийн векселийн үндсэн төлбөрт 390.0 тэрбум, хүүгийн төлбөрт 23.7 тэрбум төгрөгийг төлсөн ба векселийн үлдэгдэл 2016 оны эцэст 307.2 тэрбум төгрөг байна. /хавсралт №5-аар харуулав/

Концесс: Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7⁹-д заасны дагуу улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээгээр байгуулсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хувиар бүртгэсэн өр 2016 оны эцсийн байдлаар 668.9 тэрбум төгрөг, үүнээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй нийт 34 гэрээний 623.1 тэрбум, орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй нийт 54 гэрээний дагуу төлөх 45.8 тэрбум төгрөг байна. /хавсралт №6-аар харуулав/

Татварын урьдчилгаа төлбөр: Оюутолгойн татварын урьдчилгаа төлбөрийн хүрээнд авсан өрийн үлдэгдэл 2015 оны эцэст 41.4 тэрбум төгрөг байсныг 2016 онд бүрэн барагдуулсанаар үлдэгдэлгүй болсон байна.

⁷ “Монголбанк төсвийн улирлын чанартай орлого, зарлагын дутагдлыг нөхөхөд зориулж тухайн санхүүгийн жил дуусахаас өмнө төлөгдсөн байх түр хугацааны зээлийг Засгийн газарт гэрээний үндсэн дээр олгож болно”

⁸ “Засгийн газар нь Монголбанкнаас энэ хуулийн 12.1.2^б-т заасан зорилгоор тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээллэг хийж болно”

⁹ Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ.

БҮЛЭГ 1. Өрийн удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрэн бүрдээгүй нь өрийн бодлого, зохицуулалтын үр дүн хангалтгүй байх шалтгаан болжээ

1.1. Монгол Улс өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд түнш орон, олон улсын хөгжлийн байгууллагаас урт хугацаатай, бага хүүтэй нэн хөнгөлөлттэй зээлийг авч ашиглаж байсан бол 2012 оноос дундаж орлоготой орны ангилалд багтах болсноор арилжааны нөхцөлтэй зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг ашиглах боломж нээгдсэн байна.

1.2. ЭЗХЯ¹⁰ 2012-2014 оны хооронд өөрийн чиг үүргийн хүрээнд Чингис бонд, Хөгжлийн банкны Самурай бонд зэрэг томоохон арилжааны зээлийн эх үүсвэрээр төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ богино хугацаанд эргэн төлөх боломжгүй авто зам зэрэг дэд бүтцийн ажилд багагүй хөрөнгийг зарцуулсан нь улсын төсөвт их хэмжээний өр, төлбөрийн дарамт бий болох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.3. Тухайн цаг үед өр үүсгэхээс эхлээд эргэн төлөгдөх хүртэлх харилцааг нарийвчлан зохицуулсан хууль эрх зүйн орчин хангалтгүй, Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай (2003), Төсвийн тухай (2011), Төсвийн тогтвортой байдлын тухай (2010), Валютын зохицуулалтын тухай (1994), Монгол Улсын Хөгжлийн банкны тухай (2011), Үнэт цаасны зах зээлийн тухай (2013) зэрэг хэд хэдэн хуулиудад өрийн асуудлууд нь салангид байдлаар туссан байсан нь Засгийн газрын өрийн удирдлагын бодлого, зохицуулалт нэгдмэл бус байсны илрэл байжээ.

1.4. Харин Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 2 дугаар сард батлагдан гарснаар өрийн нэгдсэн удирдлагатай болох үндэс суурь тавигдсан байна.

Өрийн удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрэн бүрдээгүй байна

График №1 Улсын өрийн удирдлага /чиг үүргийн хуваарилалт/

1.5. Аудитын дээд байгууллагуудын Олон улсын байгууллагын дэргэдэх Олон Улсын Хөгжлийн Агентлагаас гаргасан удирдамжид заасан тогтолцооны загварт үндэслэн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа өрийн удирдлагын бүтцийг үндсэн 3 чиглэлээр харьцуулж үзлээ.

Урд оффис буюу багцын удирдлага	Дунд оффис буюу эрсдэлийн удирдлага	Хойд оффис буюу бүртгэл, мэдээллийн удирдлага
- Гэрээ хэлэлцээр - Өр үүсгэх - Дотоод хөрөнгийн зах зээлийн хөгжил - Хувийн хэвшлийн түншлэл - Гадаад түншлэл - Олон улсын санхүүгийн байгууллагууд	- Өрийн стратеги - Өр зээлийн хэрэгцээ шаардлага - Эрсдэлийн шинжилгээ - Эрсдэлийн үнэлгээ	- Бүртгэлжүүлэлт - Төлбөр тооцоо - Тайлагнах - Гүйлгээний бүртгэл - Системийн удирдлага - Нягтлан бодох бүртгэл - Өрийн статистик мэдээ - Хөрөнгө, өр төлбөр

1.6. Өрийн удирдлагын тухай хуультай¹¹ болсноор өрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, өрийн удирдлагын стратегийн баримт бичиг, эрх зүйн акт боловсруулах, өрийн тогтвортой байдлын болон эрсдэлийн үнэлгээ, шинжилгээ хийх, төлбөр тооцоо, бүртгэл тайлагнал, статистик гэх зэрэг чиг үүргүүд, тэдгээрийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагууд зохих ёсоор зохион байгуулагдсан байна.

1.7. Харин эдгээр байгууллагуудын чиг үүрэг буюу үйл ажиллагааны гарц, үр дүнгийн чанарыг хангуулах дотоод хяналтын тогтолцоо болон өрийн мэдээллийн харилцан уялдаа, нийцлийг хангуулахад чиглэсэн нэгдмэл арга, технологи бий болоогүй байна.

1.8. Өрийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус Өрийн удирдлагын зөвлөлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулах талаар Өрийн удирдлагын тухай хуулинд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор “Өрийн

¹⁰ 2012 онд шинээр байгуулагдсан ЭЗХЯ-ны үндсэн чиг үүрэгт Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хэтийн, дунд, богино хугацааны стратеги, үндсэн чиглэл, төлөвлөгөө, төсөөлөл, хөрөнгө оруулалт, худалдааны бодлогыг нэгтгэн боловсруулж, хөгжлийн бодлогын уялдааг хангах үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл, тусламжийн бодлогыг нэгтгэн боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, гадаадын хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах зэрэг асуудлууд багтаж байсан байна.

¹¹ Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “Өрийн удирдлага гэж Засгийн газрын богино, дунд хугацааны санхүүгийн зардал, эрсдэлийн түвшинг тодорхойлсны үндсэн дээр стратеги боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах, хяналт тавих үйл ажиллагааг” хэлнэ гэж заасан

удирдлагын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан боловч тус зөвлөл байгуулагдаагүй байна.

1.9. Ингэснээр тус зөвлөлийн авч хэлэлцэх Засгийн газрын өрийн удирдлагын бодлого, стратегийн төлөв байдал, өрийн зохицуулалтын үйл ажиллагааг явуулах, дүгнэх зэрэг өрийн удирдлагын үр нөлөөг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжээгүй явж иржээ.

Өр үүсгэх хэрэгцээ шаардлагыг оновчтой төлөвлөөгүйгээс зарим төсөл үр дүнд хүрээгүй байна

1.10. Салбарын зарим яамд гадаадын зээлээр хэрэгжүүлэх төслийн хэрэгцээ шаардлагыг оновчтой төлөвлөөгүй, ТЭЗҮ-ийг боловсруулаагүй, зээл, тусламжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрсдэлийг удирдаагүй зэрэг шалтгааны улмаас зарим төсөл зорилт, үр дүндээ хүрээгүй байна. Тухайлбал:

- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх” төслийн зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн хөрөнгөөс 28.6 сая ам.долларын үнэтэй машин механизм 2013 оноос хойш өнөөг хүртэл ашиглалтгүй, өмчлөгч нь тодорхойгүй, бүртгэлд аваагүй, зээлийн хөрөнгийг төлөх эх үүсвэр тодорхойгүй байгаа,
- БСШУСЯ-ны “Энэтхэг-Монголын хамтарсан мэдээлэл технологийн боловсрол болон аутсорсинг төв барих” болон “Шинэ зууны боловсрол” төсөл, ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл” төсөл газрын болон тоног төхөөрөмж суурилуулах зөвшөөрөл аваагүй, ТЭЗҮ-ийг боловсруулаагүй гэх зэргээр бэлтгэл ажил хангагдаагүй,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Орон сууцны хороолол, дэд бүтэц”-ийн төслийн хүрээнд хийгдэх “МҮОНРТ орчмын орон сууцны хорооллуудын инженерийн шугам сүлжээ барих” ажлаас дэд станцуудын зураг төсөв дутуу хийгдсэн, тухайн үед мөрдөгдөж байсан стандарт өөрчлөгдсөн зэргээс шалтгаалж нэмэлт ажлууд гарч, төслийн хэрэгжих хугацаа удааширсан,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Хот байгуулалтын салбар Мон-2301” төслийн Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн НААҮБ-ын эзэмшлийн хэлбэрийг өөрчилж, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх ажил хэрэгжээгүй,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Шинэ төмөр зам” төслийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл, төмөр замын трасс, царигийг барих төрийн бодлого өөрчлөгдсөнөөс төслийн ажил удааширч, бүрэн ашиглалтад ороогүй байна.

Өрийн удирдлагын дунд хугацааны зорилт бүрэн биелээгүй байна

1.11. УИХ-ын 2015 оны 51 дүгээр тогтоолоор “Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг”-т бодлогын 4 зорилтыг баталсан бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг тооцож үзлээ. Үүнд:

Хүснэгт №3 Дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын зорилт

№	Үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжилт
1	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж, батлуулах /2015 оны сүүлийн хагас жилд/	2015 оны сүүлийн хагас жилд батлуулах	хэрэгжээгүй
2	Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахад авах шаардлагатай арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх /2016-2018 он/	2016-2018 он	хэрэгжээгүй
3	Гадаад хөрөнгө оруулагчдын харилцааг сайжруулах, мэдээллээр хангах арга хэмжээг жил бүр тогтмол авч хэрэгжүүлэх /АНУ, Европ, Ази, Ойрхи Дорнодын бүс нутгийг хамарч байх/	2015 оноос эхлэн жил бүрийн эхний хагас жил	хэрэгжсэн
4	Засгийн газрын үнэт цаасны зах зээлд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид чөлөөтэй оролцох боломжийг нээх, хөрвөх чадварыг сайжруулах, зах зээлийн жишиг хүүг тогтоох зорилгоор төвлөрсөн хадгаламжийн дэд бүтцийг сайжруулж, автоматжуулах /2016 он/	2016 он	хэрэгжсэн

1.12. Олон улсад зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудаас манай улсын зээлжих зэрэглэлийг сүүлийн нэг жилийн дотор нэг шатлалаар бууруулж хөрөнгө оруулалтын өндөр эрсдэлтэй ангилалд оруулсан байна. Үүнд:

Хүснэгт №4

Мүүдис компани /Moody's/			Стандарт энд Пуурс компани (S&P)		Мүүдис компани /Moody's/		Фитч компани /Fitch/	
Огноо	2016.08.26		2016.08.19		2016.11.22		2016.11.22	
Ангилал	Өмнөх	Сүүлийн	Өмнөх	Сүүлийн	Өмнөх	Сүүлийн	Өмнөх	Сүүлийн
	B ₂ сөрөг	B ₃ сөрөг	B ₃ сөрөг	CAA1 тогтвортой	B тогтвортой	B- тогтвортой	B тогтвортой	B- тогтвортой
Эх сурвалж: Сангийн яам								

Эх сурвалж: Сангийн яам

1.13. Зээлжих зэрэглэл ийнхүү буурсан нь нэг талаас улс орны эдийн засгийн төлөв байдал суларч, дунд хугацаанд ДНБ-ий өсөлт буурсан, Засгийн газрын гадаад өрийн

хэмжээ өссөн, гадаадын хөрөнгө оруулалт буурсан, гадаад валютын нөөц багассан, эдийн засагт нөлөө үзүүлэхүйц төсөл, хөтөлбөрүүдийн явц удааширсан зэрэг нөхцөл байдал нөлөөлсөн байна.

Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг шинэчлэх шаардлага үүссэн байна

1.14. “Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг”-т дунд хугацааны бодлогын хүрээнд хүрэх үр дүнг 4 үзүүлэлтээр, он тус бүрээр тодорхойлсон бөгөөд биелэлтийг үнэлэхэд дараах үр дүнтэй байна. Үүнд:

Хүснэгт №5

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлтийн						2017 онд хүрэх үр дүн	2018 онд хүрэх үр дүн
		2015 онд хүрэх үр дүн	2015 онд хүрсэн үр дүн	хангасан эсэх	2016 онд хүрэх үр дүн	2016 онд хүрсэн үр дүн	хангасан эсэх		
1	Засгийн газрын өрийн үлдэгдлийн өөрчлөлтийг харьцуулсан харьцаа	8.1 хувь	7.8 хувь	Тийм	2.5 хувь	32.9 хувь	Үгүй	2.2 хувь	1.0 хувь
2	Засгийн газрын нийт өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацаа	6 жил	6.2 жил	Үгүй	7 жил	5.5 жил	Үгүй	7.2 жил	7.5 жил
3	Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа	17.2 хувь	14.4 хувь	Тийм	12.0 хувь	23.0 хувь	Үгүй	10.5 хувь	8.0 хувь
4	Засгийн газрын дотоод үнэт цаасыг барьцаалж гаргах Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийн хэмжээ	1.0 их наяд төгрөг	993.1 тбм төгрөг	Тийм	1.0 их наяд төгрөг	1.2 их наяд төгрөг	Үгүй	1.0 их наяд төгрөг	1.0 их наяд

1.15. Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа тогтоосон хязгаараас 30.4 пунктээр, Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 11.0 пунктээр тус тус хэтэрсэн байгаа нь 2016 онд гадаад валютын ханш өссөн¹², мөн ДНБ-ий өсөлт хангагдаагүй, нийт дүнгээрээ төлөвлөснөөс 3.7 их наяд төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

1.16. Засгийн газрын нийт өрийн багцын гадаад валютаар илэрхийлсэн өр төлбөрт¹³ ам.доллар 69.3 хувь, зээлжих тусгай эрх /ЗТЭ/¹⁴ 11.2 хувь, иен 14.1 хувь, евро 3.2 хувь, бусад валют 2.2 хувийг тус тус эзэлж байгаа нь гадаад валютын ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж, төгрөгөөр илэрхийлэгдэх дүнг их хэмжээгээр өсгөхөд нөлөөлж байна.

1.17. Тухайлбал, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн валютын ханшийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ам.долларын эсрэг 24.8 хувиар, еврогийн эсрэг 19.5 хувиар, иений эсрэг 27.9 хувиар, вонны эсрэг 21.2 хувиар тус тус төгрөгийн ханш суларсан байна.

Хүснэгт №6 Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэлд нөлөөлсөн ханшийн өөрчлөлт /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015.12.31	Нэмэгдсэн	Хорогдсон	Чөлөөлсөн	Ханшийн өөрчлөлт	2016.12.31
Гадаад зээл	4,565.4	1,350.1	135.6	37.4	1,240.9	6,983.4
Засгийн газрын гадаад үнэт цаас	3,315.8	1,021.2	-	-	1,043.4	5,380.4
Засгийн газрын баталгаатай зээллэг	2,743.5	188.7	189.1	-	708.3	3,451.4
Дүн	10,624.7	2,560.0	324.7	37.4	2,992.6	15,815.2

1.18. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2016 онд огцом суларч ханшийн өөрчлөлтөөс 2.9 их наяд төгрөгөөр Засгийн газрын өрийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн байна.

1.19. Ийнхүү 2015 онд стратегийн баримт бичгийг боловсруулах үеийн макро эдийн засгийн төсөөлөл сүүлийн жилүүдэд ихээхэн өөрчлөгдсөн, энэ хандлага 2017 онд хэвээр хадгалагдах магадлалтай, тодруулбал, ДНБ-ий хэмжээ төлөвлөснөөс 17 хувиар дутуу биелэх, гадаад валютын ханш 10 орчим хувиар өсөх хандлагатай байгаагаас үзэхэд тус баримт бичигт тусгагдсан 2017-2018 оны хүрэх үр дүн мөн хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

¹² Голлох валют болох ам.доллар 2016 оны эцэст өмнөх үеэс 24.8 хувиар өссөн, мөн ТТБТХ-ийн 8.2-т (...албан ханш ... 15.0 хувь ба түүнээс дээш хувиар өссөн тохиолдолд төсвийн тусгай шаардлагыг түр хугацаагаар түтгэлзүүлж болно) гэж заасан.

¹³ Засгийн газрын нийт өрийн багцын 75.1 хувийг гадаад валютаар илэрхийлсэн өр төлбөр эзэлж байна.

¹⁴ ЗТЭ нь ОУВС-аас тодорхойлдог гадаад валютын багцаас бүрддэг ба үүнд АНУ-ын доллар 41.73%, Евро 30.93%, БНХАУ-ын юань 10.92%, Японы иен 8.33%, Их Британы паунд 8.09% ордог. Эдгээр валютын ханшаар ЗТЭ-ийн тухайн өдрийн ханш тодорхойлогддог.

1.20. Иймд Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹⁵-д заасны дагуу дээрх баримт бичгийг макро эдийн засгийн өнөөгийн түвшин, хандлагад тулгуурлан шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн байна.

Өрийн мэдээллийг ялгаатай аргачлалуудаар боловсруулж байна

1.21. Монгол Улсын нийт өрийн талаарх тоон мэдээллийг Монголбанк ам.доллараар, Сангийн яам төгрөгөөр мэдээлж байна. Тухайлбал, Засгийн газрын гадаад өрийн мэдээллийг бэлтгэхдээ Монголбанкны тухайд ОУВС-гийн аргачлал, Сангийн яамны тухайд Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-40.3-д¹⁶ заасныг баримталж байгаатай холбоотой байна.

Хүснэгт №7 Засгийн газрын гадаад өр

Үзүүлэлт	2013 он		2014 он		2015 он		2016 он	
	Монголбанк /сая ам.доллар/	Сангийн яам /тбм төгрөг/	Монголбанк /сая ам.доллар/	Сангийн яам /тбм төгрөг/	Монголбанк /сая ам.доллар/	Сангийн яам /тбм төгрөг/	Монголбанк /сая ам.доллар/	Сангийн яам /тбм төгрөг/
Нийт	3,684.3	7,254.6	3,609.6	9,351.9	3,647.9	10,624.7	4,894.5	15,815.3
Гадаад зээл	2,184.3	3,613.2	2,109.6	3,979.1	2,230.1	4,565.4	2,805.1	6,983.3
Гадаад үнэт цаас	1,500.0	2,481.2	1,500.0	2,828.4	1,417.8	3,315.8	2,047.0	5,380.5
Засгийн газрын баталгаа	-	1,160.2	-	2,544.4	-	2,743.5	-	3,451.5
Богино хугацаат бусад өглөг	-	-	-	-	-	-	42.4	-

1.22. Аргачлалууд ялгаатай байгаагаас шалтгаалаад өрийн мэдээлэлд дараах байдлаар зөрүү гарч байна. Тухайлбал:

Хүснэгт №8

Монголбанк	Сангийн яам
Өрийн үлдэгдлийг ам.доллараар гаргаж байна. ОУВС-гаас гаргасан төлбөрийн тэнцлийн 6 дугаар аргачлал (BPM-6)-ын дагуу хоёрдогч зах зээлд арилжаалагдаж буй гадаад үнэт цаасыг тухайн тайлант өдрийн зах зээлийн үнэлгээгээр тооцон бүртгэж байна. Засгийн газрын өрийн баталгаатай гадаад зээллэгийг тухайн зээллэг хийсэн институцийн аль салбарт хамаарахаас шалтгаалан Бусад салбарын ангилалд ¹⁷ оруулж бүртгэж байна. Монгол Улсад бүртгэлгүй аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй Засгийн газрын дотоод үнэт цаасыг Гадаад үнэт цаасны бүртгэлд оруулж байна.	Өрийн үлдэгдлийг төгрөгөөр гаргаж байна. Гадаад үнэт цаасны өрийн бүртгэлийг нэрлэсэн үнээр бүртгэж байна. Засгийн газрын өрийн баталгаатай гадаад зээллэгийг Гадаад өрийн бүтцэд оруулж бүртгэж байна. Монгол Улсад бүртгэлгүй аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй Засгийн газрын үнэт цаасыг Дотоод үнэт цаасны бүртгэлд оруулж байна.

1.23. Жишээ нь Сангийн яам болон Монголбанкны 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болгосон Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдлийн бүртгэлийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №9

д/д	Үнэт цаас	Арилжааны үнэ	Огноо	/сая ам.доллар/	
				Нэрлэсэн үлдэгдэл	Зах зээлийн үнэлгээгээр
1	Чингис бонд	96.688	12/30/2016	500.0	483.4
2	Чингис бонд	85.825	12/30/2016	1,000.0	858.3
3	Дим сам бонд ¹⁸	94.621	12/14/2016	161.2	152.6
4	Мазаалай бонд	105.4	12/30/2016	500.0	527.0
5	Монгол Улсад бүртгэлгүй этгээдийн эзэмшиж буй Засгийн газрын дотоод үнэт цаас ¹⁹				25.7
Нийт дүн				2,161.2	2,047.0
				<i>Эх сурвалж: Сангийн яам</i>	

¹⁵ Макро эдийн засгийн голлох үзүүлэлтийн хэлбэлзлээс шалтгаалан дунд хугацааны төсөөлөлд суурилсан өрийн багцын зорилтот түвшинд хүрэх боломжгүй болсноос бусад тохиолдолд стратегийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

¹⁶ 40.1 "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарыг өнөөгийн үнэ цэнээр тооцож, бүртгэнэ", 40.2 "Засгийн газрын гадаад зээлийн гэрээний мэдээллийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулах бөгөөд зээлийн ашиглалт гарсан өдрөөс эхлэн өрд бүртгэнэ", 40.3 "Засгийн газрын болон аймаг, нийслэлийн үнэт цаасыг төлбөр тооцоо хийгдсэн өдрөөр нь өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, өрд бүртгэнэ"

¹⁷ Монгол Улсын Хөгжлийн банкны Засгийн газрын баталгаатай зээллэг нь бусад салбарууд ангилалд багтаж байна.

¹⁸ Тус бондыг БНХАУ-ын юаниар /1.0 тэрбум юань/ анх гаргасан бөгөөд Засгийн газар своп хэлцэл хийж, ам.долларт хөрвүүлсэн

¹⁹ Голланд Улсын ING банк нь Монгол Улсын Засгийн газрын дотоод үнэт цаасыг эзэмшиж байна.

БҮЛЭГ 2. Өрийн зохистой түвшин алдагдаж, өрийн хэмжээ сэрэмжлэх түвшинд хүрсэн байна

Өрийн тусгай шаардлагын түвшинг тогтвортой баримтлахгүй байна

2.1. Өрийн тухай төсвийн тусгай шаардлага буюу тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-д эзлэх өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн хувь, хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тогтоож өгдөг.

2.2. Харин гадаад, дотоодын зах зээлээс хамаарч Монгол Улсын голлох экспортын бүтээгдэхүүний үнэ буурах, макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн төсөөлөл болон хүлээгдэж буй гүйцэтгэлийн зөрүүтэй байдлаас шалтгаалан Засгийн газрын өрийн хэмжээнд тавигдах тусгай шаардлага биелэхээргүй нөхцөл байдал үүсэх үед хуульд өөрчлөлт оруулан, өрийн хязгаарыг нэмэгдүүлэх замаар өрийн тусгай шаардлагыг хангах нөхцөлийг бий болгож иржээ.

2.3. Тухайлбал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр өөрчилж, ДНБ-д эзлэх өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Улсын²⁰ өрийн үлдэгдлийн хувь хэмжээг 2015 онд 58.3 хувь, 2016 онд 55.0 хувиас хэтрэхгүй байхаар заасан боловч өрийн хэмжээ огцом нэмэгдэж тусгай шаардлага хангагдахгүй нөхцөл үүсэх үед тус хуульд 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр дахин өөрчлөлт оруулж, тусгай шаардлагыг 2016 онд 55.0 хувь байсныг 88.0 хувиас хэтрэхгүй байхаар өөрчлөлт оруулсан.

Хүснэгт №10 Засгийн газрын өрийн тусгай шаардлагын түвшинг хуульд оруулсан эцсийн өөрчлөлтөөр харуулбал,

Үзүүлэлт	2013 он				2014 он				2015 он				2016 он			
	ТТБТХ	ТХМ	ТТБТХ	ТХМ	ТТБТХ	ТХМ	ТТБТХ	ТХМ	ТТБТХ	ТХМ	ТТБТХ	ТХМ	ТТБТХ	ТХМ	ТТБТХ	ТХМ
Засгийн газрын өр /ӨҮЦ/ тбм.төг		Хүрэх 8,114.6	Хүрсэн 8,757.5		Хүрэх 8,201.2	Хүрсэн 11,871.6			Хүрэх 13,740.0	Хүрсэн 12,124.2			Хүрэх 21,299.1	Хүрсэн 18,861.0		
ДНБ-д эзлэх хувь	50.0	46.0	49.9	40.0	40.0	54.1	58.3	58.3	52.3	88.0	88.0	79.0				

2.4. Өрийн тусгай шаардлага 2013, 2014 онуудад хангагдаагүй байсан бол хуульд өөрчлөлт оруулсан онуудад буюу 2015, 2016 онуудад хангагдсан гэж харагдаж байгаа бөгөөд тогтоосон хязгаарыг 3 жилийн дотор үнийн дүнгээр тооцвол 2.6 дахин, ДНБ-д харьцуулсан хувиар тооцвол 38 пунктээр нэмэгдүүлсэн байна.

Өрийн тогтворгүй байдал үүсч сэрэмжлэх түвшинд хүрсэн байна

2.5. Монгол Улсын Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг ОУВС-гийн аргачлалд түшиглэн тооцож үзлээ.

Хүснэгт №11 Өрийн тогтвортой байдлын индикатор үзүүлэлт

Үзүүлэлтүүд		2013	2014	2015	2016	Шалгуур үзүүлэлт
1	Гадаад өрийн үлдэгдэл (ӨҮЦ) / ДНБ	27.4	33.2	36.3	53.7	40 хувь
2	Гадаад өрийн үлдэгдэл (ӨҮЦ) / Экспорт	90.9	74.1	95.6	123.3	150 хувь
3	Гадаад өрийн үлдэгдэл (ӨҮЦ) / Төсвийн орлого	87.7	117.0	140.3	219.3	250 хувь
4	Гадаад өрийн үйлчилгээ / Экспорт	5.0	5.0	5.3	7.5	20 хувь
5	Гадаад өрийн үйлчилгээний төлбөр / Төсвийн орлого	4.8	7.9	7.8	13.3	30 хувь

Эх сурвалж: Сангийн яам

2.6. Манай улс 2016 оны байдлаар өрийн тогтвортой байдлын 1 индикатор үзүүлэлт /Гадаад өр/ДНБ-ийг хангаагүй²¹ байгаа нь өрийн удирдлага тогтвортой хэрэгжиж чадаагүй, зохистой түвшин алдагдсан, өрийн дарамтад орох эрсдэлтэй байгааг харуулж байна.


2.7. Мөн гадаад өр болон өрийн үйлчилгээний төлбөрийг төсвийн орлогод, мөн экспортод харьцуулсан индикатор үзүүлэлтүүдийг хангаж байгаа боловч 2013 оноос харьцаа муудаж ирсэн хандлагаас харвал сэрэмжлэх түвшинд ойртож байна.

²⁰ Өрийн удирдлагын хууль батлагдсанаар Засгийн газрын өрөөр тодорхойлох болсон

²¹ Олон улсын жишгээр 3 нь хангагдаагүй тохиолдолд тухайн улсыг өрийн дарамтад орох эрсдэлтэй гэж үздэг

Гадаад валютын албан нөөцийн хэмжээ богино хугацаат гадаад өр төлбөрийг барагдуулахад хүрэлцэхээргүй хэмжээнд байна

График №2 Гадаадын хөрөнгө оруулалт, экспортын орлого, гадаад валютын албан нөөц /сая ам.доллараар/



2.8. 2013 онд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 15,729.2 сая ам.доллар байсан бол 2016 онд 2,748.8 сая ам.доллараар буурч 12,980.4 сая ам.долларт хүрсэн байна.

2.9. Харин гадаад валютын албан нөөц 2013 онд 2,248.0 сая ам.доллар байсан бол жил бүр буурсаар 2016 онд 1,296.3 сая ам.долларт хүрсэн байна.

2.10. ОУВС-гийн аргачлалаар тооцож үзэхэд Монгол Улсын гадаад валютын улсын нөөц нь 2014-2016 онд үндсэн 3²² шаардлагаас 1 шаардлагыг хангаагүй явж иржээ.

График №3 Богино хугацаат өр төлбөрийг төлөхөд хүрэлцээтэй байдал




2.11. Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2015-2016 оны байдлаар богино хугацаат гадаад өр төлбөрөө барагдуулж хүрэлцэхээргүй байна.

2.12. Графикаас харахад санхүүгийн хэрэгслийн өр төлбөрийг төлөх үед төлбөрийн чадваргүйд хүрэх эрсдэл гарч болзошгүй байна.

Эх сурвалж: Монголбанк

График №4 Гадаад валютын албан нөөц импортын 3 сарын хэрэгцээг санхүүжүүлж байгаа байдал /улирлаар/




2.13. Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2014 оны 2 дугаар сард хамгийн их буюу 9.5 сарын импортын хэрэгцээг хангах, 2014 оны 7 дугаар сард хамгийн бага буюу 2.8 сарын импортын хэрэгцээг хангах хэмжээний нөөцтэй байсан.

2.14. Монгол Улсын гадаад валютын албан нөөц импортын хэрэгцээг бүрэн санхүүжүүлэх хэмжээнд байгаа нь ОУВС-гийн жишиг үзүүлэлтэд нийцэж байна.

Эх сурвалж: Монголбанк


График №5 Эдийн засагт байгаа нийт мөнгөний 20 хувьтай тэнцэх байдал



2.15. Эдийн засагт байгаа нийт²³ мөнгөний дунджаар 27 хувийг гадаад валютын албан нөөц эзэлж байгаа нь ОУВС-гаас тогтоосон жишиг үзүүлэлтэд нийцэж байна.

Эх сурвалж: Монголбанк

График № 6 Гадаад валютын цэвэр нөөц



2.16. Харин Монгол Улсын гадаад валютын цэвэр нөөц²⁴ 2013 оны эхэнд 3,713.0 сая ам.доллар байсан бол 2014 оны 11 сараас эхлэн сүүлийн 2 жил хасах үзүүлэлттэй байсаар 2016 оны эцэст (429.1) сая ам.долларт хүрсэн нь гадаад валютын цэвэр нөөц хомсдолд орсныг харуулж байна.

Эх сурвалж: Монголбанк

²² 1.Богино хугацаатай /1 жил хүртлэх/ гадаад өрийг 100 хувь төлөх, 2.Импортын 3 сарын хэрэгцээг бүрэн санхүүжүүлэх

²³ Эдийн засагт байгаа нийт мөнгөний 20 хувьтай тэнцэж байх

²⁴ М2 = М1/хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах данс/ + төгрөгийн хадгаламж + гадаад валютын хадгаламж + гадаад валютын харилцах


²⁴ Валютын Зохицуулалтын тухай хуулийн 4.3-т "Монгол Улсын болон төрийн эрх бүхий байгууллагын эзэмшилд байгаа валютын гадаад цэвэр нөөцийг валютын гадаад нөөц тус бүрийн нийт дүнгээс гадаадаас авсан холбогдох богино хугацаат зээл, хадгаламжийг хасаж тодорхойлно" гэж заасан.

2.17. Монгол Улсын гадаад валютын цэвэр нөөц сүүлийн 2 жилээс эхлэн тогтмол буурч байгаа нь төгрөгийн эсрэг гадаад валютын ханш өсөх, гадаад өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулахад хүндрэл үүсч, өр нэмж үүсгэхэд нөлөөлж байна.

Төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөхгүй байгаа нь дотоод өр нэмэгдэх, хүүгийн зардалд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үндсэн шалтгаан болж байна

2.18. 2016 оны жилийн эцэст улсын төсвийн алдагдал 3.5 их наяд төгрөгт хүрч, 2013 оноос 5.2 дахин, 2014 оноос 1.6 дахин, 2015 оноос 3.0 дахин их нэмэгдсэн нь тухайн онуудад төсвийн орлогыг анхнаасаа үндэслэлтэй төлөвлөөгүйгээс төсвийн жилийн явцад санхүүжилтийн байнгын дутагдал бий болж, бонд ихээр гаргах, улмаар хүүгийн нэмэлт зардалд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах нөхцөлийг бүрдүүлж иржээ.

График №7 Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /2016 оны байдлаар/ тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Сангийн яам

2.19. Улсын Их Хурлаас Монгол Улсын төсвийг он, онд батлахдаа тухайн тайлант онд шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны дээд хязгаарыг тогтоолгүй, зөвхөн он дамжих үнэт цаасны үлдэгдлийн хэмжээг баталж байгаа нь Засгийн газар дотоод үнэт цаасыг оны туршид ямар нэг хязгаарлалтгүйгээр арилжаалж, их хэмжээний өрийн үйлчилгээний зардал гарах шалтгаан болж байна.

2.20. 2012 оноос эхлэн Засгийн газрын үнэт цаасыг²⁵ анхдагч зах зээлд тогтмол арилжаалж байгаа ба энэ хугацаанд 2012-2016 онд нийт 11.7 их наяд төгрөгийн үнэт цаасыг дотоодын зах зээлд нээлттэй болон хаалттай хэлбэрээр гаргасан ба хүүгийн төлбөрт 1.1 их наяд төгрөг зарцуулжээ.

2.21. Нийт гаргасан үнэт цаасны 80.8 хувийг 12 долоо хоногоос 1 жил хүртэлх богино хугацаатай үнэт цаас, 19.2 хувь нь 1.5 жилээс 10 жил хүртэлх дунд болон урт хугацаатай үнэт цаас эзэлж байна.

2.22. 2013-2016 онд гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны 9.3 их наяд буюу 79.4 хувийг улсын төсвийн, 0.8 их наяд буюу 6.4 хувийг ХХС-гийн алдагдлыг нөхөхөд 1.7 их наяд төгрөг буюу 14.2 хувийг тусгай зориулалтаар гаргасан үнэт цаас эзэлж байна.

Хүснэгт №12

Зориулалт	2013 он	2014 он	2015 он	2016 он	Дүн
Улсын төсвийн алдагдал	2,593.0	2,253.9	2,360.8	2,066.7	9,274.4
Хүний хөгжил сангийн алдагдал	55.7	269.7	184.7	239.9	750.0
Төслийн төлбөрт	-	65.0	-	-	65.0
Сайн хөтөлбөр	-	-	-	596.0	596.0
Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө нэмэгдүүлэх	-	-	-	1,000.0	1,000.0
Нийт дүн	2,648.7	2,588.6	2,545.5	3,902.6	11,685.4

Эх сурвалж: Сангийн яам

2.23. Үүнээс тусгай зориулалтаар дараах үнэт цаасыг гаргасан байна.


- Улсын төсөвт тусгаагүй “Сайн малчин”, “Сайн оюутан”, “Сайн хашаа”, “Сайн хувьцаа” хөтөлбөрт зориулж нийт 596.0 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаснаас²⁶ 142.3 тэрбум төгрөгийг буцаан төлж, үлдэгдэл 453.7 тэрбум төгрөг,

²⁵ “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль, Засгийн газрын 1996 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын бонд гаргах, арилжаалах журам”^{25а}, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 217/А-161 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”, Засгийн газрын 2014 оны 371 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжих журам”-аар тус тус зохицуулж байна.

²⁶ Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр батлах тухай Засгийн газрын 2016 оны 114, “Сайн оюутан” батлах тухай Засгийн газрын 2016 оны 229, “Сайн хашаа” хөтөлбөр батлах тухай Засгийн газрын 2016 оны 312, “Сайн хувьцаа” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2016 оны 334 дүгээр тогтоолыг тус тус баталсан.

- Засгийн газрын 2014 оны 123 дугаар тогтоолын дагуу MCS компани²⁷-д бичсэн 65.0 тэрбум төгрөгийн үнэт цаас байна.

График №8 /Эх сурвалж: Монголбанк /жигнэсэн дундаж хүү, хувиар/



2.24. Засгийн газрын үнэт цаасны хүүгийн хэмжээ 2013 оноос хойш тогтмол өсч Монголбанкны бодлогын хүү болон арилжааны банкны хадгаламжийн хүүгээс өндөр болсон нь улмаар зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдүүлэх үр дагаврыг үүсгэж, эдийн засгийн өсөлтийг бууруулахад тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлж байна.

Засгийн газрын өрийн хүлээгдэж буй төлбөрийн хуваарь нь төсөвт их хэмжээний ачаалал үзүүлэхээр байна

2.25. Засгийн газрын 2012-2016 онд үүссэн гадаад болон дотоод өр төлбөрийн эргэн төлөлт хийх хуваарь нь 2017-2023 оны хооронд төсөвт их хэмжээний ачааллыг үзүүлэхээр байна. Үүнд:




График №9 Засгийн газрын гадаад өр болон баталгаатай зээллэгийн эргэн төлөлтийн хуваарь /сая ам.доллараар/

Эх сурвалж: Сангийн яам

2.26. Дараах томоохон гадаад төлбөрүүд ойрын 5 жилд эргэн төлөгдөх хуваарьтай байна. Тухайлбал,

- 2018 оны 1 дүгээр сард 500.0 сая ам.долларын Чингис бондын,
- 2018 оны 6 дугаар сард 161.2 сая ам.долларын Дим сам бондын /своп хэлцлийн/,
- 2021 оны 4 дүгээр сард 500.0 сая ам.долларын Мазаалай бондын,
- 2022 оны 12 дугаар сард 1.0 тэрбум ам.долларын Чингис бондын,
- 2023 онд Хөгжлийн банкны 30.0 тэрбум иений Самурай бондын

График №10 Засгийн газраас дотоодод гаргасан үнэт цаасны эргэн төлөлтийн хуваарь /тэрбум төгрөг/



2.27. Дотоод эх үүсвэрийн эргэн төлөлтөөс 2017 онд хамгийн их буюу 3.4 их наяд төгрөг төлөхөөр байна.

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт №13

Валют	Улс, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх хуваарь				Нийт дүн
	2017 он	2018 он	2019 он	2020 он	
Ам.доллар /сая/	61.9	62.4	56.7	5.6	186.6
Юань /сая/	355.1	210.5	197.2	183.8	946.6
Төгрөг /тбм/	118.6	72.4	67.4	22.7	281.1

2.28. Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр барих-шилжүүлэх төрлийн олон тооны

концессын гэрээг төсөвт ирэх ачаалал, эдийн засгийн үр өгөөжийг харгалзалгүй байгуулснаас концессын гэрээний хэрэгжилтийн эргэн төлөлтөөс 2017 онд хамгийн их

²⁷ УИХ-ын 2008 оны 47, 2009 оны 49 дүгээр тогтоолын хүрээнд өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх санхүүжилтийн нөхцөлтэйгээр хэрэгжсэн /Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн 2 хэлхээтэй 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110 кВт-ын дэд станцын барилга угсралтын ажил/ төсөл, арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлэх зорилгоор 2011 онд Сангийн яам, ЭБЭХЯ, MCS компанийн хооронд 39/143 дугаар төлбөр тооцооны гэрээг байгуулж, MCS компани төслийн ажлыг гүйцэтгэжээ.

төлбөр буюу 61.9 сая ам.доллар, 355.1 сая юань, 118.6 тэрбум төгрөгийн төлбөрийг төлөхөөр байгаа нь төсвийн өрийн дарамтыг нэмэгдүүлж болзошгүй байна.

Нэгдсэн төсвийн зарлагын дүнд эзлэх өрийн үйлчилгээний хүүгийн зардлын эзлэх хувь хэмжээ нэмэгдсээр байна

График №11 Нэгдсэн төсвийн зарлага болон хүүгийн зардал /тэрбум төгрөг/



2.29. Засгийн газрын өрийн нэрлэсэн хэмжээ 2016 оны эцэст 22.3 их наяд төгрөгт хүрч ДНБ-ий 93.3 хувийг эзэлж байгаа нь ирэх онуудад хүүгийн төлбөрийн зардал ихээр нэмэгдэх, улмаар дунд хугацаанд нэгдсэн төсвийн орлогын багагүй хувийг зөвхөн хүүгийн зардалд зарцуулах нөхцөл үүсээд байна.

2.30. Засгийн газар 2013-2016 онд өрийн үйлчилгээний хүүгийн төлбөрт нийт 3.9 их наяд төгрөг зарцуулжээ.

2.31. Хүүгийн зардал 2016 онд 1.0 их наяд төгрөг буюу нийт төсвийн зарлагын 10.4 хувьд хүрсэн нь 2013 онтой харьцуулахад 3.6 дахин, 2015 онтой харьцуулахад 32.8 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.

БҮЛЭГ 3. Өр үүсгэж бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй, валютын ханшийн эрсдэлийг удирдаагүйгээс үр ашиггүй нэмэлт зардал гарсаар байна

Өр үүсгэж бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна

3.1. Гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх зарим төслийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг судлаагүй, үндсэн зорилтоо хангаагүй, хугацаа хэт удааширалтай, хөрөнгийн ашиглалт хангалтгүй, бүртгэлд тусгаагүй зэргээс өр үүсгэж бий болсон хөрөнгийн үр ашиг хангалтгүй, үр өгөөж гараагүй байна. Тухайлбал:

Өр үүсгэж бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй байгаа төслүүд:


- “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал” төслийн /Японы ОУХА-ны банк/ менежментийн асуудлыг анх төлөвлөхдөө орхигдуулснаас хүчин чадлаар бүрэн ашиглаж эхлээгүй,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Хот байгуулалтын салбар Мон 2301” төслөөс /АХБ/ Нийслэлийн авто замын газар /хуучнаар/-ын лабораторт 2010 онд нийлүүлэгдсэн 55.6 сая төгрөгийн өртөг бүхий далангийн нягт чийг багажийг стандартад тохироогүй улмаас огт ашиглаагүй, мөн замын тэгш байдлыг хэмжигч бамп интегратор багажны програм хангамжийг ажиллуулж чадахгүйгээс шалтгаалж хүчин чадлаар нь ашиглах боломжгүй,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх” төслөөр /БНХАУ/ нийлүүлэгдсэн хөрөнгөөс 9.9 сая ам.долларын үнэтэй 5 зүтгүүр, 28.6 сая ам.долларын үнэтэй төмөр замын зам завсар, арчилгааны нийт 65 ширхэг машин механизм ашиглалтгүй,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Ази-Европын уулзалт (АСЕМ)-ыг зохион байгуулахад ашиглагдах автобусыг нийлүүлэхэд хамтран ажиллах, цаашлаад үр ашигтай нийтийн тээврийн сүлжээг (хот хоорондын зорчигчдийг тээвэрлэх) бий болгоход туслалцаа үзүүлэх” төслийн /БНСУ/ хүрээнд нийлүүлэгдсэн 5.5 сая ам.долларын үнэ бүхий том оврын 43²⁸ автобус ашиглалтгүй,
- ЭХЯ-ны “Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцын шинэчлэл” /ХБНГУ-ын 8.5 сая евро/ төсөл хэрэгжиж дууссан боловч зээлийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгээгүй, дотоодын техник хяналт хийгдээгүйгээс улсын комисс хүлээж аваагүй, зээлийн хөрөнгийн тооцоог хийж баталгаажаагүй,

Бэлтгэл ажил, хэрэгцээ шаардлагын судалгаа бүрэн хийгдээгүй төслүүд:

- ЗГХЭГ-ын “Ухаалаг засаг” төслийн /Дэлхийн банк/ зарим арга хэмжээ, БСШУСЯ-ны “Шинэ зууны боловсрол” /БНХАУ/, ХНХЯ-ны “Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх” зэрэг төслийг /АХБ/ хэрэгжүүлэх явцад Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсон, бэлтгэл ажлыг бүрэн хангаагүй зэргээс үндсэн зорилтдоо хүрээгүй,
- ЭМСЯ-ны /хуучин нэрээр/ “Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-5” төслийн /АХБ/ гүйцэтгэгчийг шалгаруулах ажил нь худалдан авах ажиллагааны журамд нийцээгүй сонгон шалгаруулалт болж төсөл үндсэн зорилтоо хангаагүй

Дамжуулан зээлдүүлсэн зээлийн 45 хувь нь төлөгдөх боломжгүй байна

График №12 Дамжуулан зээлийн үлдэгдэл /салбараар/




3.2. Монгол Улсын гадаад эх үүсвэрээс авсан зээлээс дотоодод дамжуулан олгосон зээлийн үлдэгдэл 2016 оны эцэст 1,777.4 тэрбум төгрөгт хүрчээ.

3.3. Дамжуулан зээлдүүлсэн зээлээс 494.9 тэрбум буюу 28 хувийг эрчим хүчний салбарт, 395.7 тэрбум буюу 22 хувийг зам тээврийн салбарт, 436.4 тэрбум буюу 25 хувийг ОСНААҮ, ХАА, харилцаа холбооны салбарт, 450.4 тэрбум буюу 25 хувийг ЖДҮ, санхүү эдийн засгийн болон бусад салбарт ашиглаж байна.

Эх сурвалж: Сангийн яам

²⁸ 2016 оны 6 сард худалдан авч Ази-Европын уулзалтын арга хэмжээнд ашигласнаас хойш “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын дулаан зогсоолд 10 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл, “Тэнүүн огоо” ХХК-ий 3-р баазын дулаан зогсоолд өнөөдрийг хүртэл хадгалж ямарч ашиглалтгүй байна

График №13 Дамжуулан зээлийн үлдэгдэл /валютаар/



Эх үүсвэр: Сангийн яам

3.4. Өмнөх онуудад олгосон дамжуулан зээлийн үлдэгдэл 1,214.1 тэрбум төгрөгийн эргэн төлөлтөд 2013-2016 онд нийт 131.3 тэрбум төгрөгийг дэд болон эцсийн зээлдэгч²⁹-ээс төлсөн нь ашигласан зээлийн 6 хувийг эзэлж байна.

3.5. Дамжуулан зээлийн 33 хувийг төгрөгөөр, 26 хувийг доллараар, 18 хувийг ЗТЭ-ээр, 23 хувийг бусад валютаар олгожээ.

3.6. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн төгрөгөөр олгосон үлдэгдэл 2016 оны эцсийн байдлаар 584.2 тэрбум төгрөг байгаагаас УИХ-ын 2010 оны 72 дугаар болон Засгийн газрын 2011 оны 139 дүгээр тогтоолыг үндэслэн Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2011 оны 276/300 дугаар хамтарсан тушаалаар гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн валютаар илэрхийлсэн зээлийг төгрөгт шилжүүлсэн үлдэгдэл 328.7 тэрбум төгрөг байна. Тухайлбал,

- БНХАУ-ын 27.0 сая ам.долларын санхүүжилтийн хүрээнд “Дөргөний усан цахилгаан станц” төслийг хэрэгжүүлэхээр Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-тай 2001 онд ам.доллараар байгуулсан гэрээний дүнг дээрх тушаалын дагуу төгрөгт шилжүүлж 31.9 тэрбум төгрөгөөр гэрээг 2012 онд шинэчлэн байгуулсан, 1,140.7 сая төгрөгийн үндсэн төлбөр, 958.2 сая төгрөгийн хуримтлагдсан хүүгийн төлбөрийг төлөөгүй, ам.долларыг төгрөгт шилжүүлсэний 35.3 тэрбум төгрөгийн ханшийн зөрүү үүссэн,
- ЕХСБХБ-ны 8.5 сая еврогийн санхүүжилтийн хүрээнд “Эрчим хүчний үр ашиг-II” төслийг хэрэгжүүлэхээр “Дулааны 4-р цахилгаан станц” ТӨХК-тай 2012 онд 15.6 тэрбум төгрөгөөр гэрээг байгуулсан боловч 20.5 тэрбум төгрөг буюу 4.9 тэрбум төгрөгийн илүү ашиглалт гарсан, эргэн төлөлт хийгдээгүй, еврог төгрөгт шилжүүлсний ханшийн зөрүүнд 2.5 сая евро буюу 6.5 тэрбум төгрөг бий болсон,
- Дэлхийн банкны 505.5 мянган ЗТЭ-ийн санхүүжилтийн хүрээнд “Эрчим хүчний төсөл”-ийг хэрэгжүүлэхээр Даланзадгад ДЦС ТӨХК-тай 2007 онд дээрх валютаар байгуулсан гэрээний дүнг дээр дурьдсан тушаалын дагуу төгрөгт шилжүүлж 929.7 сая төгрөгөөр гэрээг 2012 онд шинэчлэн байгуулсан, Засгийн газрын 2013 оны 3 дугаар тогтоол, ТӨХ-ны 2013 оны 185 дугаар тогтоолоор Дэлхийн банкны санхүүжүүлсэн хөрөнгөөс 686.9 сая төгрөгийн хөрөнгө ӨБЦТС ТӨХК-нд, 242.8 сая төгрөгийн хөрөнгө Даланзадгад ДЦС ТӨХК-нд шилжсэн боловч тус тусын дүнгээр гэрээг шинэчлэн байгуулаагүй, 231.9 сая төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөөгүй,

3.7. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлээс зам тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ОСНААҮ-ний салбарт олгосон 521.7 тэрбум, 1991-1996 оны хооронд 124 аж ахуйн нэгж, иргэнтэй байгуулсан гэрээ болон холбогдох нотлох баримтгүй, эзэн холбогдогч тодорхойгүй 269.2 тэрбум, нийт 790.9 тэрбум буюу 45 хувь нь эргэн төлөгдөх боломжгүй, найдваргүй зээл байна. Тухайлбал,

- “УБДС” ТӨХК-нд хэрэгжиж буй “Дулааны үр ашгийг дээшлүүлэх” төслийн хүрээнд тус компани эцсийн зээлдэгч ОСНААҮГ-тай 16.0 сая ам.долларын гэрээг байгуулсан боловч³⁰ гэрээний үнийн дүнг төгрөгт шилжүүлээгүй, усны үнэ, тарифын хувьд төрөөс зохицуулалттай, санхүү, төлбөрийн чадваргүй зэргээс зээлийн үлдэгдэл 15.2 сая ам.долларыг буцаан төлүүлэхэд хүндрэлтэй болжээ,
- 1998-2002 оны хооронд нийт 13 аймгийн³¹ ЗДТГ-т /АХБ/ орон нутгийн нийтийн аж ахуйн газрыг хөгжүүлэх төслийн хүрээнд олгосон зээлээс 23.1 тэрбум төгрөг найдваргүй,
- НЗДТГ-ын “Улаанбаатар хотын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах төсөл-1” болон “Улаанбаатар хотын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах төсөл-2” /Дэлхийн банкны 12.3 сая ЗТЭ-тэй тэнцэх төгрөг/ төсөл нь эргэн төлөлт хийгдээгүй, найдваргүй болсон.

Гадаадын валютын ханшийн эрсдэлийг зохистой удирдаагүйгээс төсвийн үр ашиггүй зардал нэмэгдсээр байна

3.8. ЭЗХЯ /хуучнаар/, Сангийн яам болон Хөгжлийн банкны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан 01/12/88 дугаар “Санхүүгийн зуучлалын гэрээ”-

²⁹ Өрийн удирдлагын тухай хуулийн 29.3-т “дэд зээлдэгч гэдэгт ...дамжуулан зээлдүүлсэн зээлийг эцсийн зээлдэгчид дамжуулан олгож байгаа ТЭЗ...”, 29.4-т “эцсийн зээлдэгч гэдэгт ...дамжуулан зээлдүүлэх гэрээний үндсэн дээр зээлийн хөрөнгийг, хүүгийн хамт эргэн төлөх нөхцөлтэйгээр авч байгаа ...хуулийн этгээд”-ыг ойлгоно.

³⁰ УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоол болон Сангийн сайд, ЭБЭХС-ын 2011 оны хамтарсан 276/300 дугаар тушаалын дагуу Эрчим хүчний салбарын ТӨХК-дын гэрээг төгрөгт шилжүүлэн, шинэчилсэн байна.

³¹ Увс-945.6 сая, Завхан 1,304.4 сая, Хөвсгөл-1,433.9 сая, Ховд 928.8 сая, Баян-Өлгий 991.1 сая, Хэнтий 2,040.2 сая, Дорноговь 1,841.4 сая, Дундговь 2,191.9 сая, Өмнөговь 1,102.2 сая, Сүхбаатар 3,068.4 сая, Дорнод 3,411.2 сая, Булган 1,727.7 сая, Архангай 2,110.7 сая

ний дагуу Сангийн яам Хөгжлийн банкинд Чингис бондын хөрөнгөөс³² 2,021.3 тэрбум төгрөг, 269.9 сая ам.долларыг улс орны эдийн засгийн хөгжилд түлхэц болохуйц томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор жилийн 4.7917 хувийн хүүтэйгээр байршуулсан байна.

3.9. Гэрээний дагуу Хөгжлийн банк Чингис бондын эх үүсвэрийг төгрөгөөр болон ам.доллараар Засгийн газарт төлж, харин Засгийн газар гадаад талдаа 2018 онд 500.0 сая ам.доллар, 2022 онд 1.0 тэрбум ам.долларыг эргэн төлнө.

3.10. Засгийн газар Чингис бондын эх үүсвэрийг Хөгжлийн банкинд ам.доллараар бүрэн байршуулалгүй, тухайн үед 1,410.2 сая ам.долларыг 1433.31 ханшаар тооцож, хөрвүүлсэн 2,021.3 тэрбум төгрөгийг 2016 оны ханшаар тооцож, буцааж ам.долларт хөрвүүлэхэд ойролцоогоор 1,489.5 тэрбум төгрөг буюу 598.3 сая ам.доллар худалдан авахтай тэнцэх хэмжээний алдагдлыг Засгийн газар хүлээж байна.

3.11. Засгийн газар, Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагын тооцоог 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон харилцан суутгал хийхийг УИХ-ын 2016 оны 81 дүгээр болон Засгийн газрын 2016 оны 219 дүгээр тогтоолоор эцэслэн шийдвэрлэжээ.

3.12. Дээрх тогтоолуудын дагуу Сангийн сайдын 2016 оны 441 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон Сангийн яамнаас Хөгжлийн банкинд өгөх өглөгийн 3,176.5 тэрбум, Хөгжлийн банкнаас Сангийн яамны авах авлагын 2,702.4 тэрбум /Чингис бондын эх үүсвэр/ төгрөгийг харилцан суутгаж, эцсийн дүнгээр Сангийн яам Хөгжлийн банкинд 474.1 тэрбум төгрөгийн өглөгтэйгээр тооцоо нийлсэн байна.

Векселийн төлбөр, концессын гэрээнүүдэд өрийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс ханшийн зөрүү болон хүүгийн нэмэлт төлбөрийн үр ашиггүй зардал гарч байна

3.13. УИХ-ын 2015 оны 7 дугаар, Засгийн газрын тогтоол³³-ын дагуу Сангийн яам нийт 432 төсөл, арга хэмжээнд 307.0 тэрбум төгрөгийн вексель бичиж 331 аж, ахуйн нэгжид /давхардсан тоогоор/ арилжааны банкаар дамжуулан үндсэн төлбөрт 284.2 тэрбум, хүүгийн төлбөрт 22.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төлж, төсвийн орлогын төлөвлөлттэй холбоотой үр ашиггүй, нэмэлт зардал гарчээ.

3.14. 2013-2016 онд концессын³⁴ барих-шилжүүлэх төрлөөр улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хэрэгжүүлэх 2.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 88 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээг 1,034.0 сая юаниар, 6 төсөл, арга хэмжээг 283.2 сая ам.доллараар гэрээ байгуулснаас 122.1 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээхээр байна.

3.15. “Ухаа худаг-Гашуунсухайт” чиглэлд төмөр замын суурь бүтэц барих төслийн ажлыг гүйцэтгүүлэхээр “Энержи Ресурс” ХХК-тай байгуулсан концессын гэрээг цуцалснаас тус компаний олон улсын зах дээр гаргасан бондын болон векселийн хүүгийн нөхөн төлбөрт 50.1 тэрбум, ханшийн зөрүүний алдагдал 36.0 тэрбум, нийт 86.1 тэрбум төгрөгийн үр ашиггүй зардал гарчээ.

3.16. “Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн авто замын барилга (60км)”-ын ажлын гүйцэтгэгч “Жиансу Жунжиан Жианшин” компанид төлөх өрийн үлдэгдэл 4.1 тэрбум төгрөгт бичсэн векселийн /203 хоногийн хугацаатай, 14.318 хувийн хүүтэй/ хүүгийн төлбөрт 588.1 сая төгрөгийг төсвөөс нэмж төлөхөөр байна.

³² УИХ-ын 2012 оны 52 дугаар болон Засгийн газрын 2012 оны 112 дугаар тогтоолын дагуу олон улсын зах зээлд 5 жилийн хугацаатай жилийн 4.125 хувийн хүүтэй 500.0 сая ам.долларын, 10 жилийн хугацаатай жилийн 5.125 хувийн хүүтэй 1,000.0 сая ам.долларын “Чингис бонд”-ыг тус тус арилжаалсан.


³³ Засгийн газрын 2015 оны 282, 2016 оны 72, 117, 239, 257 дугаар тогтоол

³⁴ Төсвийн тухай хуульд 2012 оны 10 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орсноор Концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төсвийн бүрэлдэхүүн хэсгээс гаргасан.

Төсвийн орлогыг зохистой төлөвлөөгүйгээс векселийн төлбөрийн хүүгийн нэмэлт зардалд төсвийн ихээхэн хэмжээний хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж иржээ

График №14 2015-2016 оны төсвийн орлогын биелэлт, бичсэн векселийн үндсэн болон хүүгийн төлбөр

3.17. УИХ-ын 2015 оны 7 дугаар, Засгийн газрын тогтоолын дагуу³⁵ Сангийн яам 2015 онд нөөцийн махны урамшууллын төлбөрт 4.5 тэрбум, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 159.8 тэрбум, 2016 онд мөн төсөл, арга хэмжээнд 143.9 тэрбум, концессын гэрээний төлбөрт 335.0 тэрбум, татварын урьдчилгаа төлбөрт 54.0 тэрбум, нийт 697.2 тэрбум, хүүгийн төлбөрт 69.6 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжүүдэд олгохоор вексель бичсэнээс 2016 оны эцэст үндсэн төлбөрт 307.2 тэрбум, хүүгийн төлбөрт 45.9 тэрбум төгрөг олгох векселийн үлдэгдэлтэй байна.



3.18. 2015-2016 онд векселиэр санхүүжүүлэх арга, хэмжээний хүрээнд үндсэн төлбөрт 390.0 тэрбум, хүүгийн төлбөрт 23.7 тэрбум, нийт 413.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс барагдуулсан байна.

3.19. Төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж ирээгүйгээс шалтгаалан улсын төсвийн хөрөнгө оруулалтад туссан боловч бүрэн санхүүжигдэлгүй үлдсэн төсөл, арга хэмжээнд бичсэн векселийн хүүгийн төлбөрт 2015 онд 12.2 тэрбум /үндсэн төлбөрт 164.3 тэрбум/, 2016 онд 57.4 тэрбум /үндсэн төлбөрт 532.9 тэрбум/, нийт 69.6 тэрбум төгрөгийг хүүгийн зардалд зарцуулж төсвөөс үр ашиггүй зардал гаргасан байна.

³⁵ Засгийн газрын 2015 оны 282, 105 дугаар тогтоолын дагуу 2008-2014 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусган хэрэгжүүлсэн хэдий ч бүрэн санхүүжигдээгүй төсөл, арга хэмжээг векселиэр баталгаажуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээс үүдэн Засгийн газрын өрд Векселийн өр гэх бүхэл бүтэн шинэ ангилал үүсч улмаар Засгийн газрын 2016 оны 72, 77, 284, 298, 117, 239, 257 тогтоол гарсан.

БҮЛЭГ 4. Өрийн мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаж чадахгүй байна

Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажил хангалтгүй хийгдэж байна

4.1. Сангийн яам өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний систем /DMFAS/-ийг 2002 оноос эхлэн ашиглан Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл, бүртгэлийг тогтмол хөтөлж, Засгийн газрын гадаад өр төлбөр, дотоод зээллэгтэй холбоотой өрийн үлдэгдэл, статистик мэдээллийг 2014 оноос эхлэн зээлдүүлэгч талтай тулган баталгаажуулж, бүртгэлийн үнэн зөв байдлыг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж иржээ. Мөн энэхүү системийг Монгол банк төв банкны өр төлбөр, бусад хувийн хэвшлийн өр, төлбөрийг бүртгэхэд ашиглаж байна.

4.2. Харин 2015 оноос Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг үнэлэх, хэрэгжилт үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлагын мэдээллийн нэгдсэн сан /ODAMIS/-г ашиглаж, 1991 оноос эхлэн Засгийн газрын шугамаар авч ашиглаж эхэлсэн 1200 гаруй төслийн мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулжээ.

4.3. Гэвч аудитаар Өрийн удирдлагын үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, удирдлагын мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг буруу оруулсан тохиолдолд эргээд залруулах боломжгүй, мөн дамжуулан зээлийн мэдээллийг мэдээллийн санд бүрэн оруулдаггүй зэрэг эрсдэлтэй нөхцөл байдал илэрсэн нь өрийн удирдлагын бодлого, стратегийн хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлөх үр дагавартай байна.

Тухайлбал,

- “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн мэдээллийг төслийн ажилтны алдаанаас мэдээллийн санд³⁶ 2 дахин оруулсан,
- “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд гарсан 5.4 тэрбум төгрөгийн, “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах” төслийн хүрээнд гарсан 1.0 тэрбум төгрөгийн ашиглалтыг тус тус мэдээллийн санд оруулаагүй байна.

Концессын талаарх мэдээллийн санг бүрдүүлээгүй байна

4.4. Үндэсний хөгжлийн газар мэдээллийн санг³⁷ үүсгээгүй, харин концессын гэрээнүүд болон бусад мэдээллийг байгууллагын цахим сайтад байршуулж байна.

4.5. Концессын асуудал эрхэлсэн Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо /2009-2012 он/, Эдийн засгийн хөгжлийн яам /2012-2014 он/, Аж үйлдвэрийн яам, Сангийн яам /2014-2016 он/, Үндэсний хөгжлийн газар /2016 он/ байгууллагууд нь Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.9-д заасан “Улсын хэмжээнд концессын талаарх нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх” ажлыг хийгээгүй, концессын талаарх мэдээллийг Excel програм дээр хөтөлж байна.

4.6. Харин Шилэн дансны тухай хуулийн дагуу концессын гэрээгээр улсын төсвөөс төлөгдөх санхүүжилтийн мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулж байна.

Олон нийтэд мэдээлэх чиг үүргээ биелүүлээгүй байна

4.7. Сангийн яам Засгийн газрын гадаад өрийн статистик мэдээг улирал бүр гарган цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлж байгаа боловч “Засгийн газрын өрийн тойм” тайланг³⁸ 2014 оноос хойш шинэчлэн байршуулаагүй байна.

4.8. Монголбанк Улсын нийт гадаад өрийн статистик мэдээг ОУВС-гаас гаргасан гадаад секторын статистикийг боловсруулах аргачлал, мэдээлэл тархаах ерөнхий

³⁶ “ODAMIS” системд мэдээллийг буруу оруулсан

³⁷ Концессын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-д “Эрх бүхий этгээд уралдаант шалгаруулалттай холбоотой аливаа баримт бичиг, материалыг нэгтгэн мэдээллийн сан үүсгэж хадгална” гэж заасан.

³⁸ Өрийн удирдлагын тухай хуулийн 9.1.15 “улсын нийт гадаад өрийн үлдэгдлийг улирал тутам Монголбанкт хамтран гаргах”, 38 дугаар зүйлийн 38.3 “Засгийн газрын өр болон өрийн баталгааны үлдэгдлийг улирал бүр, дунд, урт хугацааны өрийн үйлчилгээний төсөөллийг жил бүр тооцоолон гаргаж, олон нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын өрийн статистик мэдээлэл, бүртгэлийг бүртгэж, мэдээлэх, тайлагнах,

системийн шаардлагын дагуу боловсруулж, улирал тутам өөрийн цахим хуудсанд тавьж олон нийтэд мэдээлж³⁹ байна.

4.9. Харин Үндэсний статистикийн хороо өрийн талаарх мэдээллийг статистикийн эмхтгэлд гаргаж олон нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй⁴⁰ байна.

4.10. Монголбанк, Сангийн яам хамтран улсын нийт гадаад өрийн статистик үзүүлэлтийг салбарын бүтцээр нэгтгэн гаргахдаа “Сангийн яам, Монголбанкны хооронд мэдээлэл солилцох журам”-ыг баримтлан цахимаар мэдээллээ солилцдог байна.

4.11. Дээрх журамд 2 тал мэдээллээ хэрхэн солилцож тооцоо нийлсэн акт үйлдэх, мэдээллийг буруу гаргаж олон нийтэд мэдээлсэн тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой болгоогүйгээс мэдээлэл зөрүүтэй гаргаж байна. Тухайлбал,

- Сангийн яам Монголбанкинд өмнөх улирлуудад гаргасан ашиглалтын мэдээг засаж, өөрчлөх үе зарим тохиолдол гардаг нь гадаад донор орнууд зээл ашиглалтын баримтаа хоцроож ирүүлдэгтэй холбоотой байна.
- Монголбанк олон нийтэд нэгэнт мэдээлсэн гадаад өрийн тоон мэдээг өөрчлөдөггүй, засварлаагүй үлдэгдэл дээр ашиглалт болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн дүнг бүртгэж, ханшийн тооцооллыг хийн тухайн улирлын мэдээг гаргадаг байна.

4.12. Гэвч гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний бүртгэл тайлагналыг үнэн зөв хийх ажил хангалтгүй, зээлийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалтанд тавих хяналт сул, хууль журмын зарим заалт мөрдөгдөхгүй байна. Тухайлбал,

- АХБ-ны санхүүжилттэй Мон-2301 төслийн хөрөнгөөр нийслэлд баригдсан “Орбит-Тахилтын 7.1 км асфальтобетон хучилттай авто зам”-ыг бүртгэлд 460.0 сая төгрөгөөр илүү дүнтэй бүртгэсэн, Нийслэлийн авто замын лабораторид хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжид Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”-ыг зөрчин 714.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан,
- ОБЕГ-т хэрэгжсэн “Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, ангийн гал унтраах техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах” /БНАУ/ төслийн 5.0 сая еврогийн үнийн дүнтэй техникийг бүртгэлд өөр валютаар тусгасан, 20.0 мянган еврогийн техникийг орлогод аваагүй байна.

³⁹ Монголбанк Төвбанкны тухай хуулийн 34.1, Өрийн удирдлагын тухай хуулийн 11.1.1-д тус тус заасны дагуу Монгол Улсын гадаад секторын статистик буюу Монгол Улсын Засгийн газрын, хувийн хэвшлийн, банкны системийн өрийн бүртгэл, статистик мэдээллийг хариуцан бүртгэж, улирал бүр тайлагнах,

⁴⁰ Өрийн удирдлагын тухай хуулийн 11.3 “улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон өрийн баталгааны талаарх мэдээллийг макро эдийн засгийн тойм мэдээнд хамаарах тоон дүн, статистик мэдээллийн хамт улирал, жилээр нэгтгэн гаргах

БҮЛЭГ 5. Өрийн удирдлагын хариуцлагатай байх зарчим бүрэн хэрэгжихгүй байна

Холбогдох шийдвэргүйгээр дотоод зээл авсан, хуульд нийцээгүй баталгаа гаргасан зөрчил гаргажээ

5.1. Монголбанк 2016 онд төсвийн улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор тухайн онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 200.0 тэрбум төгрөгийн зээлийг Засгийн газрын шийдвэргүйгээр Сангийн яаманд олгосон нь “Монголбанкнаас Засгийн газарт зээл олгох, төлүүлэх журам”⁴¹-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-т⁴² заасныг зөрчсөн байна.

5.2. Засгийн газар нь 2015-2016 онд нийтдээ 600.4 сая ам.долларын, 128.0 тэрбум төгрөгийн зээллэгт аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн⁴³ үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор⁴⁴ баталгаа гаргасан боловч зарим баталгаа нь хуульд нийцээгүй байна. Тухайлбал:

- “Эрдэнэс Монгол” ХХК⁴⁵, Голомт банкны⁴⁶ хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд баталгаа гаргасан нь Өрийн удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зээллэгийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ нь ..улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан байх..” гэж заасныг зөрчсөн байна.

5.3. Дээрх зөрчлүүд нь Өрийн удирдлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т “Өрийн удирдлагын хэрэгжилтэд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу жил бүр дотоод аудит хийнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Төслийн хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна

5.4. Сангийн яам болон салбар яамд, хэрэгжүүлэгч байгууллагаас зарим гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжсэн төслийн нэгжийг байгуулаагүй, төслийн хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлт, үр дүнд тавих хяналт-үнэлгээг хангалтгүй хэрэгжүүлж иржээ. Тухайлбал:

- БСШУСЯ-ны “Энэтхэг-Монголын хамтарсан мэдээлэл технологийн боловсрол болон аутсорсинг төв барих” /Энэтхэг Улсын 20.0 сая ам.доллар/ болон “Шинэ зууны боловсрол” /БНХАУ-ын 45.6 сая ам.доллар/ төслийн нэгжийг байгуулаагүй, гэрээний үүргийн биелэлт, үр дүнг тооцож хяналт үнэлгээ хийгээгүй,
- ЭБЭХЯ-ны “Дарханы ДЦС-ын турбинг сайжруулах” /ХБНГУ-ын 10.5 сая евро/ төслийн гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, хугацааг сунгаж, төсөв 11.1 сая еврогоор нэмэгдсэн,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Мон 2301”, “Мон 3244”, “Мон 3245”, “Мон-3388” төслүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу⁴⁷ хяналт, шинжилгээ, үнэлгээ хийгээгүй,
- НЗДТГ-ын “Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах” болон “Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих” /БНХАУ-ын 72.6 сая ам.доллар/ төслийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг гаргаагүй, хяналт тавьж, биелэлтийг дүгнэж баталгаажуулаагүй,

⁴¹ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 255 дугаар тушаалаар баталсан

⁴² Монголбанкнаас зээл авах талаар гаргасан Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн

⁴³ Өрийн удирдлагын тухай хуулийн 33.4.1-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан

хуулийн этгээд”, мөн хуулийн 33.4.2-д “Энэ хуулийн 33.4.1-д зааснаас бусад дотоодын хөрөнгө оруулалт бүхий Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд”

⁴⁴ Өрийн удирдлагын тухай хуулийн 33.1 “Засгийн газар нь Хөгжлийн банкны авах зээллэгт болон энэ хуулийн 33.4-т заасан хуулийн этгээдийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болно”

⁴⁵ Засгийн газрын 2016 оны 138-р тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ий үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх нийт 42.0 сая ам.долларын санхүүжилттэй төслийн зээлийн 85 хувьд буюу АХБ-наас авах 35.0 сая ам.долларын, 15 жилийн хугацаатай техник тусалцааны зээлд,

⁴⁶ алтны үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 256.0 тэрбум хүртэлх төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банкаар дамжуулан 14 сарын хугацаатайгаар санхүүжүүлж дээрх эх үүсвэрийн 128 тэрбум төгрөг хүртэлх санхүүжилтэд Засгийн газрын баталгаа гаргасан.

⁴⁷ Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 “Яам төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран тухайн салбарт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хагас жил тутамд хяналт, шинжилгээ хийх бөгөөд шаардлагатай бол холбогдох хяналтын байгууллага, албан тушаалтныг татан оролцуулж болно”, Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан журмын 16 дугаар зүйлийн 16.1 “Төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ үнэлгээг жил бүрээр, дунд хугацааны хяналт-шинжилгээ үнэлгээг төсөл хэрэгжих дунд хугацаанд, төсөл хэрэгжиж дууссаны дараахь эцсийн хяналт-шинжилгээ үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн нэгж тус тус хариуцан зохион байгуулна. Тухайн үнэлгээний үр дүнгийн талаар гадаадын зээл, тусламжийн асуудал хариуцсан байгууллагын гадаадын зээл, тусламжийн хэрэгжилтийн асуудал эрхэлсэн нэгжид тухай бүр хүргүүлнэ.”, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан журмын 24 дүгээр зүйлийн 24.1 “ТХН-ийн ХШҮ-ний ажилтан төсөл, арга хэмжээний

- ЭМЯ-ны “Ховд аймгийн Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төв”-ийг бэхжүүлэх /Бельги Улс/, “Цахим эрүүл мэнд төсөл” /БНХАУ/ төслийн нэгж байгуулаагүй, удирдлагын мэдээллийн нэгдсэн сан /ODAMIS/-д мэдээллийг оруулаагүй, үр дүнг тооцох ажил хийгдээгүй, хууль зөрчин туслан гүйцэтгэгчийг шалгаруулсан,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Орон сууцны хороолол, дэд бүтэц” төсөлд нийт 117.4 сая ам.долларын /БНХАУ-ын тал 99.9 сая ам.доллар, Монголын тал 17.5 сая ам.доллар/ санхүүжилтээс 91.8 мянган ам.долларыг дутуу тооцож гэрээ байгуулсан, захиалагчийн зөвшөөрөлгүй туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах” /БНХАУ/ төслийн хүрээнд “Усан хангамж болон ариутгах татуургын систем”-ийн барилга байгууламжийн зарим ажил гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй,
- НЗДТГ дээр дамжуулан зээлдүүлсэн гэрээгээр хэрэгжиж байгаа төслийн үйл ажиллагаа, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

5.5. Эдгээр нь Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8⁴⁸, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.2⁴⁹, Өрийн удирдлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5⁵⁰-д болон Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10.1.12⁵¹, 10.1.17⁵²-д болон 24.2⁵³-т заасныг тус тус зөрчсөн байна.

Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна

5.6. Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг зохицуулж байгаа Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-д заасан барьцааны гэрээг байгуулах, зээлийн төлбөрийг төвлөрүүлэх, хариуцлага ногдуулах, тооцоо нийлэх тухай зарим заалтыг хэрэгжүүлээгүй, зээлийн гэрээ байгуулаагүй, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж иржээ.Тухайлбал:

- НЗДТГ-ын “Хот байгуулалтын” /АХБ-ны 8.7 сая ЗТЭ-тэй тэнцэх төгрөг/ төсөлд ашиглалтын тооцоог хийж, баталгаажуулаагүй, үлдэгдэл 531.6 сая төгрөг зөрүүтэй, хүүгийн төлбөрт 857.5 сая төгрөгийг төлөөгүй,
- ҮХААЯ-ны “ХАА-н бага оврын трактор худалдан авах” төсөл тооцоо нийлээгүй, 1.04 сая ам.долларын хүүг төлөөгүй, “Газар тариалангийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмж худалдан авах” төсөл 724.2 мянган ам.долларын хүүг төлөөгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, /БНХАУ-ын 40.0 сая ам.долларын санхүүжилттэй /
- ЭБЭХЯ-ны “Дулааны 4-р цахилгаан станц” ТӨХК дээр хэрэгжиж байгаа “Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх” /Японы ОУХА-ын байгууллагын 4.2 тэрбум иен/ төсөл хүүгийн төлбөрийг төлөөгүй,
- УБТЗ ХНН-д Төмөр замын тээврийг сайжруулахад зориулж /Японы ОУХА-ны банкны 7,892.1 сая иен/ олгосон зээлийн 3,089.8 сая иений хүүгийн болон үндсэн төлбөрийг төлөөгүй, 1,359.2 сая иений алданги тооцогдсон,
- Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХК-нд хэрэгжиж байгаа Эрчим хүчний төсөл үндсэн төлбөр 420.6 сая, хүүгийн төлбөр 78.0 сая төгрөгийг төлөөгүй,
- Эрчим хүчний төслийн хүрээнд 2001-2011 онд /Дэлхийн банк/ 10 ТӨХК-нд олгосон зээлээс зарим төрийн өмчит байгууллагууд 7.5 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөөгүй, /Алтай-Улиастайн ЭХС ТӨХК-668.7 сая, Баян-Өлгий ЦШСГазар-2,136.6 сая, Ховд ЦТС ХХК-1,752.6 сая, Увс ЦТС ХХК-2,044.0 сая, ӨБЦТСүлжээ-686.9 сая, Даланзадгад ДЦС ТӨХК-242.8 сая/

хэрэгжилтэд улирлын давтамжтайгаар хяналт-шинжилгээг хийж, энэхүү журмын 10 дугаар Хавсралтын дагуу хяналт-шинжилгээний тайланг боловсруулан Удирдлагын мэдээллийн системд оруулах ба ТУХ-нд хагас жил тутам танилцуулна.”,

⁴⁸ 2 болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар шаардлагатай арга хэмжээ авах

⁴⁹ “гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно”

⁵⁰ “ТЭЗ болон төсөл хэрэгжүүлэгч нь тухайн салбарт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ...”

⁵¹ Төслийн хүрээнд нийлүүлэгдэх бараа, ажил, үйлчилгээ үзүүлэхээр сонгон шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах, түүний биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, дүгнэх

⁵² гадаад зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдэх бараа, ажил, үйлчилгээ болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлын даалгаврын биелэлтийг дүгнэж, баталгаажуулах

⁵³ Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэсэг нь төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүр дараа жилийн эхний улиралд багтаан хийх ..., тайланг удирдлагын мэдээллийн системд оруулна”

- ЗТБХБЯ-ны “Мон-2301” /АХБ/ төслийн 2008-2014 онуудад 10 аймаг, нийслэлийн ЗДТГ, 2 банкинд олгосон 50.9 тэрбум төгрөгөөс аймгууд эргэн төлөлтөө хийгээгүй,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Орон сууцны салбарын санхүүжилт төсөл”-ийн /АХБ-ны 11.8 сая ЗТЭ/ хүрээнд 2004 онд 7.6 сая ЗТЭ-тэй тэнцэх зээлийг Анод банкинд олгосон боловч тус банк дампуурч 2.6 тэрбум төгрөгийн зээл төлөгдөөгүй,
- ЗТБХБЯ-ны /хуучин нэрээр/ “Орон сууцны хороолол, дэд бүтэц” төсөл гэрээний эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэн байгуулаагүй, эргэн төлөлт хийгдээгүй,
- Дамжуулан зээлийн гэрээ байгуулсан Дундговь болон Дархан-Уул аймгийн ЗДТГ Сангийн яамтай тооцоо нийлээгүй,
- 1987-2001 оны хооронд дамжуулан олгосон зээлээс 320.3 тэрбум төгрөгийн зээлийн гэрээ хийгдээгүй байна.

5.7. Үүнээс үзэхэд Сангийн яам, “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын 8 дугаар зүйлийн 8.5⁵⁴-д заасан чиг үүргийг хангалтгүй хэрэгжүүлж иржээ. Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуульд үндэслэн 2006 онд гарсан тус журмыг Өрийн удирдлагын тухай хуультай уялдуулан шинэчлэх шаардлагатай байна.

Концессын гэрээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна

5.8. Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага концессын гэрээгээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд мониторинг хийж, хэрэгжилт, үр дүнг үнэлэх ажлыг хийгээгүй нь Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8⁵⁵, концесс эзэмшигчийг шалгаруулах ажлын хэсгийн гишүүдэд цалин, урамшуулал олгосон нь Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоол⁵⁶ болон ТӨХ-ны 2011 оны 677 дугаар тогтоолоор баталсан “Концесс олгох уралдаант шалгаруулалтын баримт бичгийг оролцогчдод худалдан борлуулж олсон орлогыг захиран зарцуулах тухай журам”-ын 3.2-т заасныг тус тус баримталж ажиллаагүй байна. Тухайлбал,

- 2014 онд ЭЗХЯ тендерийн бичиг баримт худалдсаны орлого 237.0 сая төгрөгөөс 152.5 сая төгрөгийг ажлын хэсэгт ажилласан гишүүдэд илүү цагийн урамшуулал болгон нэг хүнд 2.0-20.0 сая төгрөг хүртэлх урамшуулал,
- 2015 онд ЭЗХЯ-ны концесс төр, хувийн хэвшлийн албаны 6 ажилтанд 2.1 сая төгрөгийг цалин хэлбэрээр,
- 2016 онд Хөрөнгө оруулалтын газар тендерийн бичиг баримт худалдсаны орлого 50.7 сая төгрөгөөс 20.6 сая төгрөгийг ажлын хэсгийн гишүүдэд урамшуулал олгосон байна.

5.9. Дээрх ажлын хэсгийн гишүүдэд илүү цагийн урамшууллыг их хэмжээгээр олгосон нь Төсвийн тухай хуулийг зөрчиж байгаа тул цаашид хууль хяналтын байгууллагаар шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

5.10. Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 5 байгууллагад⁵⁷ нийт 2.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлагыг YAG-аас өглөө.

⁵⁴ 8.5 “...зээлийн төлбөрийг дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасан хугацаанд эргүүлэн төлөөгүй болон энэхүү журам, зээлийн хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд Сангийн яам зээлийг хэсэгчлэн, эсхүл бүрэн хэмжээгээр зогсоох, төсөл хэрэгжүүлэх эрхийг түтгэлзүүлэх, холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулах, ... зэрэг шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ”

⁵⁵ “концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх

⁵⁶ “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”-ын 4.г-д “Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог тусгай газрын дарга нар 10 хүртэл албан хаагчийг 100,000 хүртэл төгрөгөөр шагнана”

⁵⁷ Онцгой байдлын ерөнхий газарт 941.2 сая, Сангийн яаманд 929.7 сая, Нийслэлийн өмчийн харилцааны газарт 460.0 сая, Нийслэлийн авто замын хөгжлийн газарт 55.6 сая төгрөгийн, Барилга хот байгуулалтын яаманд илэрсэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгсөн.

Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Өрийн удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрэн бүрдээгүйгээс Засгийн газрын өрийн бодлого, зохицуулалтын үр дүн хангалтгүй, дунд хугацааны зорилт биелээгүй байна.
2. Өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг 2015 онд боловсруулах үеийн макро эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөж, дунд хугацааны хандлагад нөлөөлснөөс тус баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлага тавигдаж байна.
3. Төсвийн тусгай шаардлагын талаарх эрх зүйн зохицуулалт тогтворгүй, өрийн зохистой түвшин алдагдаж, сэрэмжлэх түвшинд хүрсэн төдийгүй олон улсын байгууллагын үнэлгээгээр Монгол Улсын зээлжих зэрэглэл буурчээ.
4. Гадаад валютын албан нөөцийн хэмжээ эрс буурч, улсын богино хугацаат гадаад өр төлбөрийг барагдуулахад хүрэлцэхээргүй хэмжээнд очжээ.
5. Төсвийн зарлага болон тэнцлийн алдагдал жилээс жилд өссөөр байгаа нь өрийн хэмжээ буурахгүй байх хүчин зүйл болж байна.
6. Засгийн газрын өрийн үйлчилгээний зардалд 2016 онд нийт төсвийн зарлагын 10.4 хувийг зарцуулсан бөгөөд өрийн хүлээгдэж буй төлбөр нь дунд хугацаанд төсөвт их хэмжээний дарамт үзүүлж болзошгүй байна.
7. Гадаадын зээлээр хэрэгжүүлсэн зарим төсөл, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс их хэмжээний хөрөнгө үр ашиггүй бэлтгэгдсэн, зарим төсөл зорилт, үр дүндээ хүрээгүй, дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.
8. Сангийн яам Засгийн газрын шийдвэргүйгээр Монголбанкнаас дотоод зээл авсан, Засгийн газар Өрийн удирдлагын тухай хуульд нийцээгүй баталгааг зарим аж ахуйн нэгжид гаргасан, төсөвт тусаагүй “Сайн” хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор ихээхэн хэмжээний үнэт цаас гаргасан, өрийн удирдлагын хэрэгжилтэд жил бүр дотоод аудит хийж байгаагүй нь өрийн удирдлагын хариуцлагатай байх зарчмыг алдагдуулжээ.
9. Улсын Их Хурлаас Монгол Улсын төсвийг он, онд батлахдаа тухайн тайлант онд шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны дээд хязгаарыг тогтоолгүй, зөвхөн он дамжих үнэт цаасны үлдэгдлийн хэмжээг баталж байгаа нь Засгийн газар дотоод үнэт цаасыг оны туршид ямар нэг хязгаарлалтгүйгээр арилжаалж, их хэмжээний өрийн үйлчилгээний зардал гарахад нөлөөлж байна.
10. Төсвийн орлогыг зохистой төлөвлөөгүйгээс векселийн төлбөрт хүүгийн нэмэлт зардал, гадаад валютын ханшийн эрсдэлийг зохистой удирдаагүйгээс концесс болон дамжуулан зээлд ханшийн зөрүүгийн нэмэлт зардал тус тус их хэмжээгээр гарч, төсвийн зарлагын ачааллыг нэмэгдүүлжээ.
11. Өрийн мэдээллийг боловсруулах аргачлал өөр өөр байгаагаас Монгол банк, Сангийн яамнаас гаргаж байгаа өрийн мэдээлэл харилцан зөрүүтэй мэдээлэгдэж байгаа нь олон нийтэд өрийн талаар зөрүүтэй ойлголт төрүүлэхээр байна.
12. Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага өрийн мэдээллийн сан бүрдүүлээгүй, өрийн мэдээллийг олон нийтэд хүргэх үүргээ зарим байгууллага биелүүлээгүйгээс өрийн мэдээллийн ил тод байдал бүрэн хангагдаагүй байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Монгол Улсын төсвийг батлахдаа тухайн тайлант онд шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны дээд хязгаарыг тогтоож байх

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг тогтоож байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон дунд хугацааны төсвийн төлөвлөлтөд тавигдаж байгаа шаардлагын талаарх эрх зүйн зохицуулалтыг тогтвортой байлгах, өрийн зохистой түвшинг хангуулж ажиллах;
- Өрийн удирдлагын тухай хуульд заасан үндэслэл, шаардлагын дагуу “Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг”- ийг шинэчлэн боловсруулж, батлуулах;
- Улсын төсөвт тусаагүй төсөл, хөтөлбөрт тусгай зориулалтын үнэт цаас гаргахгүй байх;
- Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон Үндэсний статистикийн хороо зэрэг өрийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах үүрэгтэй байгууллагууд хуулийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах;
- Төсвийн орлогын төлөвлөлтийг оновчтой болгох замаар өрийн хэрэгслийн хүүгийн нэмэлт зардлаас үүдэн гарах төсвийн үр ашиггүй зардлыг бууруулахад анхаарч ажиллах;

Сангийн сайдад:

- Өрийн удирдлагын зөвлөлийг байгуулж, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах;
- Гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах арга хэрэгслийг нэвтрүүлэх замаар өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын үр дүнг дээшлүүлэх;
- Өрийн бодлого, зорилтын хэрэгжилт, үр дүнд тавих хяналт, түүний үр нөлөөг сайжруулах;
- Дамжуулан зээлээс үүссэн насжилт өндөртэй зээлийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллаж үр дүнг тооцох;
- Өрийн удирдлагын мэдээллийн нэгдсэн санг бүрэн бүрдүүлэх, өрийн мэдээллийн ил тод байдлыг хангуулж ажиллах;
- “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ыг Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж ажиллах

Хавсралт

Хавсралт №1 Засгийн газрын гадаад зээлийн 2016 оны жилийн эцсийн үлдэгдэл

№	Зээлдүүлэгч гадаад орон, Олон Улсын байгууллага	2012 оны эцсийн үлдэгдэл	2013-2016 оны				2016 оны эцсийн үлдэгдэл
			ашиглалт	эргэн төлөлт	чөлөөлөлт	ханшийн зөрүү	
1	Япон	574.4	778.0	121.1	-	337.1	1,568.4
2	Солонгос	84.7	46.1	15.8	-	53.4	168.4
3	Хятад	313.1	394.1	14.8	37.4	436.3	1,091.3
4	Герман	141.0	52.5	22.1	-	71.4	242.8
5	Азийн хөгжлийн банк	845.5	563.8	169.3	-	564.1	1,804.1
6	Дэлхийн банк	652.5	92.8	63.3	-	368.0	1,050.0
7	Нордикийн хөгжлийн сан	46.8	-	6.4	-	21.8	62.2
8	Арабын эдийн засгийг хөгжүүлэх Кувейтын сан	53.5	22.9	26.9	-	47.3	96.8
9	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан	29.8	13.8	4.8	-	18.1	56.9
10	Абу-даби сан	11.6	-	5.4	-	7.3	13.5
11	Испани	18.8	-	8.4	-	6.6	17.0
12	Итали	5.3	-	5.3	-	-	-
13	ОУВС	107.8	-	107.8	-	-	-
14	Франц	18.2	10.7	1.9	-	11.9	38.9
15	Финлянд	1.7	-	1.7	-	-	-
16	Бельги	8.4	-	1.9	-	5.5	12.0
17	Болгар	-	2.9	2.9	-	-	-
18	Энэтхэг	35.8	2.6	0.5	-	29.8	67.7
19	Польш	0.2	0.4	0.6	-	-	-
20	Орос	-	-	0.3	-	-	-
21	Швед	4.7	-	1.5	-	1.8	5.0
22	Австри	-	73.1	-	-	12.9	86.0
23	Европын хөрөнгө оруулалтын банк	-	4.9	-	-	0.3	5.2
24	Швейцарийн Кредит свисс банк	-	486.7	-	-	110.8	597.5
Нийт дүн		2,954.1	2,545.3	582.7	37.4	2,104.0	6,983.3

Хавсралт №2 Засгийн газрын гадаад үнэт цаасны 2016 оны жилийн эцсийн үлдэгдэл

№	Үнэт цаасны дугаар	Зээлдүүлэгч	2012 оны эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн				Ханшийн өөрчлөлт				2016 оны эцсийн үлдэгдэл
				2013	2014	2015	2016	2013	2014	2015	2016	
1	Чингис-12-0.5	Олон Улсын хөрөнгө оруулагч	696.1	-	-	-	-	131	115.8	882.2	246.8	1,244.8
2	Чингис-12-1.0	Олон Улсын хөрөнгө оруулагч	1,392.1	-	-	-	-	262	231.5	1,764.5	493.6	2,489.5
3	Димсам	Олон Улсын хөрөнгө оруулагч	-	-	-	316.4	-	-	-	5.4	79.6	401.4
4	Мазаалай	Олон Улсын хөрөнгө оруулагч	-	-	-	-	1,021.2	-	-	-	223.5	1,244.8
Нийт дүн			2,088.2	-	-	316.4	1,021.2	393.0	347.3	2,652.1	1,043.5	5,380.5

Хавсралт №3 Засгийн газрын баталгаатай зээллэгийн 2016 оны жилийн эцсийн үлдэгдэл

№	Баталгаа гаргуулагч	Баталгааны дугаар	Зээлдүүлэгч	Валют	Зээллэгийн огноо	Баталгаа гаргасан дүн /сая нэгж/	Үлдэгдэл		
							сая нэгжээр	тбм төгрөг	Төгрөг
1.Засгийн газрын өрийн баталгаа							Үндсэн валют	Ам.доллар	Төгрөг
1.1	Хөгжлийн банк	DBM-580	Global Investors	USD	3/21/2012	600.0	580.0	580.0	1,443.9
1.2	МИАТ	MIAT-1	PEFCO	USD	12/24/2013	77.5	51.0	51.0	126.9
1.3	МИАТ	MIAT-2	ING Capital	USD	12/24/2013	24.0	12.9	12.9	31.9
1.4	МИАТ	MIAT-3	ING Bank N.V	USD	12/24/2013	20.0	20.0	20.0	49.8
1.5	Хөгжлийн банк	DBM-30	Japan Investors	JPY	1/6/204	30,000.0	30,000.0	255.3	635.7
1.6	Хөгжлийн банк	DBM-162	China development bank	USD	9/3/2014	162.0	162.0	162.0	403.3
1.7	Хөгжлийн банк	DBM-300	Credit Suisse	USD	9/5/2014	300.0	300.0	300.0	746.9
1.8	Хөгжлийн банк	VTB-300	VTB	USD	6/15/2016	65.4	-	-	-
1.9	Аж ахуй нэгж	Gold-128	Голомт банк	MNT	5/1/2016	128,000.0	-	-	-
1.10	Эрдэнэс Монгол ХХК	EM-35	ADB	USD	4/1/2016	35.0	5.2	5.2	13.1
Нийт дүн								1,386.4	3,451.5
2.Засгийн газрын дотоод үнэт цаасаар баталгаажсан									
2.1	Худалдаа хөгжлийн банк	TDB-500*	Олон улсын хөрөнгө оруулагч	USD	5/19/2015	500.0	500.0	500.0	1,244.8
Нийт дүн								500.0	1,244.8

Хавсралт №4 Засгийн газрын дотоод үнэт цаасны 2016 оны жилийн эцсийн үлдэгдэл

№	Зориулалт	2012 оны эцсийн үлдэгдэл	2013 он		2014 он		2015 он		2016 он		Ханшийн зөрүү	2016 оны эцсийн үлдэгдэл
			гаргалт	эргэн төлөлт	гаргалт	эргэн төлөлт	гаргалт	эргэн төлөлт	гаргалт	эргэн төлөлт		
1	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх үнэт цаас	367.4	2,593.0	1,450.3	2,253.8	1,320.0	2,360.8	1,843.7	2,066.7	1,390.6	-	3,358.9
2	Хүний хөгжил сангийн алдагдал	313.1	55.7	108.1	269.7	55.0	184.6	190.2	239.9	182.2	81.6	609.1
3	Төслийн төлбөр	-	-	-	65.0	-	-	-	-	-	-	65.0
4	"4000 айлын орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд	72.0	-	28.0	-	10.0	-	30.0	-	2.0	-	2.0

	гаргасан үнэт цаас											
5	Банкны бүтцийн өөрчлөлтөд гаргасан үнэт цаас	60.0	-	27.0	-	11.0	-	11.0	-	11.0	-	-
6	ЖДҮ, ноос, ноолуурын салбарын үнэт цаас	367.4	-	181.0	-	9.3	-	4.5	-	2.3	-	-
7	Сайн хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	596.0	142.3	-	453.7
8	Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө нэмэгдүүлэх Нийт дүн	-	-	-	-	-	-	-	1,000.0	-	-	1,000.0
		1,009.5	2,648.7	1,794.4	2,588.6	1,405.3	2,545.5	2,079.4	3,902.5	1,730.4	81.6	5,488.7

Тайлбар:

Хүний хөгжил санд гаргасан дотоод үнэт цааснаас 2014 онд 115.0 сая, 2015 онд 70.0 сая ам.доллар, 2016 онд 60.0 сая ам.долларын дотоод үнэт цаас гаргаснаас ханшийн зөрүү үүссэн байна.

Хавсралт №5 Засгийн газрын векселийн 2016 оны эцсийн үлдэгдэл

№	Векселийн нэр	Засгийн газрын тогтоолын дугаар	Засгийн газрын тогтоолоор баталгаажуулсан векселийн тоо	үндсэн төлбөр дүн	2015-2016 оны эргэн төлөлт		2016 оны эцсийн үлдэгдэл	
					үндсэн төлбөр	хүүгийн төлбөр	үндсэн төлбөр	хүүгийн төлбөр
1	Махны вексель	105	4	4.5	4.5	-	-	-
2	Хөрөнгө оруулалтын вексель-2015	282	331	159.8	159.8	12.2	-	-
3	Татварын буцаан олголт	-	1	54.0	54.0	-	-	-
4	Төмөр замын вексель-Ухаа худаг-Гашуунсухайт" чиглэлд төмөр замын суурь бүтэц барих	478	1	119.5	-	-	119.5	18.2
5	Төмөр замын вексель- Ухаа худаг-Гашуунсухайт" чиглэлд төмөр замын суурь бүтэц барих /бондын хүү/	284	1	31.9	31.9	-	-	-
6	Төмөр замын вексель- Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ий төмөр замын Хандгайт өртөө хүртлэх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих	77	1	183.6	-	-	183.6	27.4
7	Хөрөнгө оруулалтын вексель-2016	72	267	124.4	124.4	10.6	-	-
8	Алтанбулаг сумыг цэвэр усны эх үүсвэртэй холбох /концесс/	72	1	0.4	0.4	0.0	-	-
9	Мандал сум чиглэлийн 15.8 км авто зам /концесс/	72	-	-	-	-	-	-
10	Түрэсийн орон сууцны худалдан авалт	298	1	15.0	15.0	0.9	-	-
11	Ховдын Булган-Үенч-Ховдын 60 км /Жиансу Жунжиан Жианшин ХХК/	195	1	4.1	-	-	4.1	0.3
	Нийт дүн		609	697.2	390.0	23.7	307.2	45.9

Хавсралт №6 Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээгээр байгуулсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хувиар бүртгэсэн Засгийн газрын өрийн 2016 оны эцсийн үлдэгдэл

1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын үлдэгдэл

№	Концессын зүйл	Гэрээ байгуулсан огноо	Валют	Гэрээний дүн		Засгийн газрын өрд бүртгэсэн дүн /тбм төг/
				Үндсэн валют /сая/	тбм төгрөг	
1	Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл	2015.03.25	USD	77.0	191.6	19.2
2	Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам төсөл	2015.06.05	CNY	377.6	135.1	135.1
3	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам төсөл	2015.03.13	CNY	569.0	203.6	203.7
4	Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто замын ажил	2015.09.25	MNT	6,952.0	7.0	4.9
5	Эгийн голын усан цахилгаан станцын урьдчилсан шатны дэд бүтцийн ажил төсөл	2015.10.21	USD	98.3	244.8	0.0
6	Нийслэлийн баянгол дүүргийн 38 дугаар дунд сургууль төсөл	2016.02.05	USD	6.7	16.7	6.7
7	Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил төсөл	2016.03.16	MNT	1,949.9	1.9	1.9
8	Хөвсгөл аймгийн Галт сумын Идэрийн голын хөвдөг гүүрний барилгын ажил төсөл	2016.03.28	MNT	787.5	0.8	0.6
9	Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ий төмөр замын Хандгайт өртөө хүртлэх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих.	2014.04.04	USD	112.7	280.5	56.1
10	Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих.	2014.04.04	MNT	95,272.2	95.3	4.8
11	Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалантын хийд чиглэлийн 63 км хатуу хучилттай авто зам	2016.07.04	USD	75.6	188.2	163.7
12	Яармагийн товчооноос жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 авто машины зогсоол барих төсөл	2016.06.24	MNT	1,762.0	1.8	1.8
13	Нийслэлийн Хан-Уул дүүрэг, 32 дугаар дунд сургууль төсөл	2016.05.19	MNT	5,800.0	5.8	3.2
14	Баянзүрх дүүрэг, 14-р дунд сургууль төсөл	2016.06.14	MNT	10,787.0	10.8	3.2
15	Хөвсгөл, Шинэ-Идэр сум, 150 ортой цэцэрлэг барих төсөл	2016.06.22	MNT	2,357.9	2.4	2.3
16	Хөвсгөл, Цагаан-Уул сум, 320 хүүхдийн сургуулийн барилга барих төсөл	1905.07.08	MNT	6,116.4	6.1	1.5
17	Хөвсгөл, Цагаан-Уул сум, 150 хүүхдийн цэцэрлэг барилга барих төсөл	2016.06.22	MNT	2,806.6	2.8	0.8
18	Ховд, Жаргалант, 1 дүгээр цэцэрлэгийн барилга барих төсөл	2016.06.24	MNT	2,105.7	2.1	0.5
19	Дундговь аймаг, Сайнцагаан сум, Цэцэрлэгийн барилга барих төсөл	2016.06.24	MNT	3,275.1	3.3	0.3
20	Дархан-Уул, Дархан сум, 100 ортой цэцэрлэг	2016.06.24	MNT	1,386.6	1.4	1.3
21	Баянхонгор аймгийн баянхонгор сумын 6-р цэцэрлэгийн 100 хүүхдийн өргөтгөлийн барилга барих төсөл	2016.04.18	MNT	1,154.0	1.2	1.1
22	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Баян ойт 1-р цэцэрлэгийн 100 ортой өргөтгөлийн барилга барих төсөл	2016.06.20	MNT	1,154.0	1.2	0.0
23	Баянхонгор аймгийн Богд суманд баригдах 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл	2016.06.20	MNT	738.2	0.7	0.2
24	Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл	2016.06.20	MNT	1,159.7	1.2	0.0

25	Баянхонгор аймгийн Шаргалжуут тосгонд баригдах 75 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл	2016.06.20	MNT	1,029.9	1.0	0.3
26	Хөвсгөл, Жаргалант сум, Цэцэрлэгийн барилга барих төсөл	2016.06.20	MNT	2,050.3	2.1	1.9
27	Хөвсгөл, Тариалан сум, Соёл, спортын цогцолборын барилга барих төсөл	2016.06.20	MNT	3,616.5	3.6	0.4
28	Төрийн тусгай хамгаалалтын газарт материал илрүүлэгч рентген төхөөрөмж нийлүүлэх төсөл	2016.04.18	MNT	2,630.5	2.6	2.6
Нийт улсын төсвөөс эргэн төлөгдөх концессын үлдэгдэл дүн						623.1
Концессын үлдэгдлийг Монголбанкны ханш /2016.12.30-ны өдөр/-ийг ашиглан тооцов. USD-2489.53\$, CNY-357.76\$						

2. Орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын үлдэгдэл

№	Концессын зүйл	валют	Гэрээний дүн	Засгийн газрын өрд бүртгэсэн дүн	/тэрбум төгрөг/
1	Баянгол дүүргийн 1 дүгээр хороо Алтай хотхоны хорооллын доторх авто замыг дунд голын авто замтай холбох гүүр барих	MNT	1.5		1.5
2	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Салхитын амны 1.9 км хатуу хучилттай авто зам барих	MNT	2.9		2.9
3	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Шадивлангийн 2.6 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил	MNT	3.2		3.2
4	Гүнтийн давааны авто замыг үргэлжлүүлэн 7.36 км авто зам барих	MNT	10.9		10.9
5	Өвөр Гүнтийн 11 км авто зам барих	MNT	13.3		12.7
6	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Яргайтын богины 1.6 км авто замын шинэчлэлт	MNT	1.7		0.5
7	Хувьсгалчдын өргөн чөлөөнөөс Хайлаастын гудамж хүртлэх 2.8 км авто зам	MNT	3.4		1.0
8	Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хороонд 41 дүгээр цэцэрлэгийн 100 хүүхдийн, өргөтгөл барих	MNT	1.2		1.2
9	Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд 121 дүгээр сургуулийн 100 хүүхдийн дотуур байрны барилга барих	MNT	2.2		2.2
10	Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, 150 хүүхдийн 144 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих	MNT	1.7		0.2
11	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороо, 83 дугаар цэцэрлэгийн 240 хүүхдийн өргөтгөлийн барилга барих	MNT	2.2		1.9
12	Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, 188 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилга барих	MNT	1.7		1.5
13	Авто тээврийн шалган бүртгэх товчоодод Мал эмнэлэг, ариун цэврийн ариутгалын пункт барих	MNT	0.5		0.02
14	Налайх дүүргийн 2 дугаар хороонд Нэгдсэн эмнэлгийн барилга барих	MNT	43.6		0.0
15	Дурсгалын цэцэрлэгт хүрээлэн	MNT	44.9		0.0
16	Орбит-Баянголын уулзвараас Найрамдал зуслан хүртэлх 15.3 км авто зам, 24.7 у/м гүүрийн өргөтгөл, шинэчлэлт хийх	MNT	26.9		0.0
17	Баянхонгор аймгийн төвд 10 км бетонон хучилттай авто зам барих	MNT	3.7		1.1
18	Сайхан сумын сургуулийн дотуур байрны 160 хүүхдийн цайны газрын барилга барих 2016-07-05-ны өдрийн 03/К/26	MNT	0.6		0.4
19	Гуулин тосгоны сургуулийн хүүхдийн дотуур байр барих /гал тогооны хамт/	MNT	0.1		0.06
20	Халиун сумын Ёлтонг цахилгааны эх үүсвэртэй болгох	MNT	0.0		0.02
21	Бигэр сумын Өөшийг цахилгааны эх үүсвэртэй болгох	MNT	0.0		0.02
22	Чандмань сумын Хүрхрээгийн услалтын системийн засвар шинэчлэл	MNT	0.1		0.04
23	Хэрлэн сумын 6, 10-р Багийн ажлын алба, агентлаг, өрхийн эмнэлэгийн барилга	MNT	0.7		0.5
24	Улиастай сумын Өлзийт багт "Иргэдийн хөгжлийн төв" барих-шилжүүлэх	MNT	0.3		0.02
25	Улиастай сумын Жинст багт "Иргэдийн хөгжлийн төв барих-шилжүүлэх	MNT	0.3		0.02
26	Улиастай сумын Жинст, Чигэстэй, Товцог багуудын гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийн шинэчлэлийн ажил	MNT	0.5		0.1
27	Хэрлэн сумын 2-р багийн нутагт 800 м хучилттай авто зам барих	MNT	0.5		0.1
28	Гудамж төсөл	MNT	31.3		3.1
29	Галданбошигт хааны нэрэмжит гудмыг тохижуулах	MNT	0.3		0.2
30	Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөл	MNT	0.3		0.2
31	Аргаль уриа Дулаан дамжуулах төв барих	MNT	0.3		0.3
Нийт орон нутгийн төсвөөс төлөгдөх концессын үлдэгдэл дүн					45.8

Холбогдох байгууллагын санал**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.06.06 № 8-3/3409

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ ДАРГА
С.ОЮУНБИЛЭГ ТАНАА**

Танайхаас 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 1000 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад, хавсралтын дагуу холбогдох тайлбар, саналыг хүргүүлж байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Б.НЯМАА

№	Тайлбар	Санал
Тайлбар №1-г үзнэ үү	1.14 “Зээлжих зэрэглэл ийнхүү буурсан нь нэг талаас улс орны эдийн засгийн төлөв байдал төлөв байдал суларч, дунд хугацаанд ДНБ-ий өсөлт буурсан, Засгийн газрын гадаад өрийн хэмжээ өссөн, гадаадын хөрөнгө оруулалт буурсан, гадаад валютын нөөц багассан, эдийн засагт нөлөө үзүүлэхүйц төсөл, хөтөлбөрүүдийн явц удааширсан зэрэг нөхцөл байдал нөлөөлсөн байна” гэж өөрчлөх	Нэмэлт тодруулга хийж өөрчлөх
Тайлбар №2-г үзнэ үү	2.2 Гадаад, дотоодын зах зээлээс хамаарч Монгол Улсын эдийн засагт үүссэн онцгой нөхцөл байдал Монгол Улсын голлох экспортын бүтээгдэхүүний үнийн бууралт, Оюутолгой ордын үйлдвэрлэлийн хэмжээ болон нүүрсний олборлолт төлөвлөсөн хэмжээнээс буурсантай холбоотойгоор ДНБ, эдийн засгийн өсөлт зэрэг макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн төсөөлөл болон хүлээгдэж буй гүйцэтгэлийн зөрүүтэй байдлаас шалтгаалан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зарим өөрчлөлтийг хийсэн.	Хасах
Тайлбар №3-г үзнэ үү	2.5 Өрийн тогтвортой байдлын шинжилгээг гүйцэтгэхэд улс орон бүрийн онцлогоос шалтгаалан I. Олон улсын зах зээлд бонд гаргасан улс орнууд (DSA-MAC) II. Бага орлоготой улс орнуудад (DSA-LIC) зориулсан 2 төрлийн арга зүй байдаг. ОУВС-гийн зүгээс Монгол Улсын хувьд 2016 оноос эхлэн олон улсын зах зээлд бонд гаргасан улс орнууд (DSA-MAC)-д нийцсэн Өрийн тогтвортой байдлын шинжилгээг гүйцэтгэж эхэлсэн. Тус шинжилгээгээр Монгол Улсын өрийг тодорхой хүчин зүйлсээс шалтгаалан урт хугацаанд тогтворжино гэж дүгнэсэн.	Нэмэлт тодруулга хийж, өөрчлөх
Тайлбар №4-г үзнэ үү	2.23 Энэхүү хэсэгт заасан холбогдох тоон мэдээллийг цаг хугацааны хувьд ижил хугацааны мэдээллийг авсан эсэх нь тодорхойгүй байх тул энэхүү мэдээллийг тодорхой нэмж оруулах	Нэмэлт тодруулга хийж, өөрчлөх
Тайлбар №5-г үзнэ үү	3.7 УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны 139 дүгээр тогтоол зэргийг үндэслэн Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2011 оны 276/300 дугаар хамтарсан тушаал батлагдсан.	Нэмэлт тодруулга хийж, өөрчлөх
Тайлбар №6-г үзнэ үү	4.1 “Сангийн яам нь өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний систем (DMFAS)-ийг 2002 оноос эхлэн ашиглаж эхэлсэн бөгөөд энэхүү мэдээллийн системд Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл, бүртгэлийг тогтмол хөтөлж байна. Түүнчлэн, энэхүү системийг Монголбанк нь төв банкны өр төлбөр болон бусад хувийн хэвшлийн өр төлбөрийг бүртгэхэд ашиглаж байна. Засгийн газрын гадаад өр төлбөр, дотоод зээллэгтэй холбоотой өрийн үлдэгдэл, статистик мэдээллийг 2014 оноос эхлэн зээлдүүлэгч талтай тулган баталгаажуулж, бүртгэлийн үнэн зөв байдлыг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж иржээ” гэж өөрчлөх	Нэмэлт тодруулга хийж, өөрчлөх
Тайлбар №7-г үзнэ үү	4.2 “Харин Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг үнэлэх, хэрэгжилт үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлагын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх зорилгоор 2015 оноос эхлэн Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээний удирдлагын мэдээллийн нэгдсэн сан (ODAMIS) системийг бий болгон, ашиглаж эхлээд байна. Энэхүү системд 1991 оноос эхлэн Засгийн газрын шугамаар ашиглаж эхэлсэн 1200 гаруй төслийн мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулсан” гэж өөрчлөх	Нэмэлт тодруулга хийж, өөрчлөх
Тайлбар №8-г үзнэ үү	5.1 Эдийн засагт үүсэн нөхцөл байдалтай холбоотойгоор төсвийн орлого төвлөрүүлэлт огцом буурч, 2017 оны 3 дугаар сарын 2-ны өдөр Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 41.6 тэрбум төгрөг болж, төсвийн зарлага санхүүжилтээ хийх боломжгүйд хүрч, төлбөр тооцоо зогсож болзошгүй эрсдэлтэй байсан тул онцгой яаралтай арга хэмжээг авч ашигласан.	Хасах
Тайлбар №9-г үзнэ үү	5.2 Энэхүү баталгааг гаргахтай холбоотойгоор Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 17 дугаар зүйлийн 17.1-т заагдсан тухайн төсвийн жилд шинээр гаргах өрийн баталгааны дээд хэмжээг УИХ тогтоох тухай заалтыг тайлбарлуулах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс тайлбар гаргуулахаар 2015 онд хандсан. Үүний дагуу Улсын дээд шүүхээс Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан өрийн баталгааны дээд хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан өрийн баталгааны үлдэгдлийг хамаарахгүй байхаар зохицуулсан байна” гэсэн тайлбарыг ирүүлсэн. Энэхүү Дээд шүүхээс өгсөн тайлбар, мөн хуулийн дагуу Хууль зүйн дотоод хэргийн яамнаас хууль зүйн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг баталгааг гаргасан.	Хасах

Тайлбар №10-г үзнэ үү	Тайлангийн Дүгнэлт хэсэг туссан: - Сангийн яамны зүгээс төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах үүднээс дагаж мөрдөх журмыг сайжруулан баталж, холбогдох сургалт семинарыг тогтмол зохион байгуулсан хэдий ч салбарын яамны тогтворгүй байдал, төсөлд тавих хяналт зэргээс шалтгаалан зарим төсөл зорилт, үр дүндээ хүрээгүй байна” гэж өөрчлөх	Нэмэлт тодруулга хийж, өөрчлөх
Тайлбар №11-г үзнэ үү	Тайлангийн Монгол Улсын Ерөнхий Сайдад зөвлөмж хэсэгт туссан: - Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу өрийн тусгай шаардлагыг ханган ажиллаж байна.	Хасах
Тайлбар №12-г үзнэ үү	Тайлангийн Сангийн сайдад зөвлөмж хэсэгт туссан: - Валютын зохицуулалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу Сангийн яам гадаад өр, төлбөрийн бүртгэлийг төгрөгөөр илэрхийлж, статистик бүртгэлийг хөтлөх, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад зээллэг хийх зэрэг хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Харин Монголбанкны бүрэн эрхийн хүрээнд Валютын зохицуулалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах үндсэн үүргийнхээ хүрээнд гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийн бодлого, төрөөс мөнгөний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлдэг. Иймд гадаад валютын ханшийн эрсдэлийг Засгийн газраас илүүтэйгээр төв банк тодорхойлж, үйл ажиллагааг Засгийн газартай хамтарч зохион байгуулах	Нэмэлт тодруулга хийж, өөрчлөх

Үндэсний аудитын газрын тайлбар

Сангийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

1. Саналыг хүлээн авч тайлангийн 10 дугаар хуудасны 1.14 дэх өгүүлбэрийг найрууллаа.
2. Саналыг хүлээн авч тайлангийн 13 дугаар хуудасны 2.2 дэх өгүүлбэрийг өөрчлөн найрууллаа.
3. Өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.
4. Холбогдох тоон мэдээллийг оны жигнэсэн дундаж хүүгийн төвшнөөр авсан болно.
5. Тайлангийн 19 дүгээр хуудасны 3.9 дэх өгүүлбэрт УИХ, Засгийн газрын тогтоолын дугаарыг нэмж орууллаа.
6. Саналыг хүлээн авч тайлангийн 22 дугаар хуудасны 4.1-д өгүүлбэрийг өөрчлөн найрууллаа.
7. Саналыг хүлээн авч тайлангийн 22 дугаар хуудасны 4.2-д өгүүлбэрийг өөрчлөн найрууллаа.
8. Саналд 2017 оны 3 дугаар сард үүссэн нөхцөл байдлыг дурьдсан тул тайлангийн 24 дүгээр хуудасны 5.1 дэх өгүүлбэрийг өөрчлөн найруулах шаардлагагүй гэж үзлээ.
9. Тайлбар, саналд үндэслэн аудитын тайлангийг 5.2-т зохих өөрчлөлт хийсэн, харин дүгнэлтийг өөрчлөх шаардлагагүй байна.
10. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавих чиг үүргийг Сангийн яам болон бусад салбар яамд аль аль нь хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй тул өгсөн зөвлөмжийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.
11. Ерөнхий сайдад өгсөн зөвлөмжийн агуулга нь өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг тогтоож байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хуулиудад олон удаа өөрчлөлт оруулж байгаа тул хуулийн заалтыг тогтвортой байлгах болон Засгийн газрын өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтээр зарим үзүүлэлт хангалтгүй байгаа нь сэрэмжлэх түвшинд ойртсон, өрийн дарамтад орох эрсдэлтэй байгаа тул өрийн зохистой түвшинг хангуулж ажиллах талаар зөвлөмж өгч байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.
12. Ирүүлсэн санал, тайлбар нь өгсөн зөвлөмжийн агуулгад нийцэхгүй байгаа тул хүлээж авах боломжгүй

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2017 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/115

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2 дахь заалт мөн 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчилд өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвлөсүгэй.


4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Давааням/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР****Д.ХҮРЭЛБААТАР**

\\10.10.10.20\Bichig_KheragiTushaai\2017\0613GAG1.docx

070487

Монгол Улсын Ерөнхий аудиторын
 2017 оны 06 дугаар сарын 09 -ны
 өдрийн 9/15 дугаар тушаалын
 хоёрдугаар хавсралт



Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

/сая.төг/				
№	Хариуцагч байгууллага	Зөрчлийн утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
1	Онцгой байдлын ерөнхий газар	Үндсэн хөрөнгөд бүртгээгүй, валютын ханшийг буруу тооцсон	01/54	941.2
2	Барилга, хот байгуулалтын яам	Гэрээ шинэчлэн байгуулаагүй	02/85	-
3	Сангийн яам	Гэрээ байгуулаагүй	01/75	929.7
4	Нийслэлийн авто замын хөгжлийн газар	НББ-ын стандартыг баримтлаагүй	02/83	55.6
5	Нийслэлийн өмчийн харилцааны газар	Бүртгэлийн дүнг залруулах	01/78	460.0
	Нийт дүн			2,386.5

[illegible]

This image shows a full page of a document template designed for handwriting practice. It consists of approximately 20 evenly spaced, horizontal blue dashed lines extending across the entire width of the page. The background is plain white, providing a clear contrast for the lines. There are no margins, text, or other markings present.

This image shows a full page of a document template designed for handwriting practice. It consists of approximately 20 evenly spaced, horizontal blue dashed lines extending across the entire width of the page. The background is plain white, providing a clear contrast for the lines. There are no margins, text, or other markings present.